

Пентатух

Хичээл 11

Гэтлэл Номын Тойм

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр хэвлэн гаргахыг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад бичээчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсрол. Бүх Дэлхийд Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн энэхүү хөтөлбөрөө хамтран ажилладаг үйлчлэлүүдээрээ дамжуулан өөр олон орны хэл рүү орчуулж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулан боловсруулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд хөгжүүлсэн. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж хийгээд арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог юм.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг Гурав дахь мянган бий болгосоор ирлээ. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийн хамтаар тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Агуулга

УДИРТГАЛ	1
АНХААРАХ ЗҮЙЛС	1
Бичээч	2
Нөхцөл байдал.....	3
Анхны Утга.....	4
Түүхэн нөхцөл.....	5
Загварууд	6
Урьдач зөн	6
Орчин үеийн Хэрэгжүүлэлт.....	9
БҮТЭЦ БА АГУУЛГА	11
Египетээс чөлөөлөгдсөн нь (Гэтлэл нь 1:1–18:27)	12
Чөлөөлөлтөөс Өмнө (1:1–4:31)	12
Чөлөөлөлтийн Үед (5:1–18:27)	14
Канаанд орох бэлтгэл (Гэтлэл нь 19:1–40:38).....	16
Израилын Гэрээ (19:1–24:11).....	17
Израилын Асар (24:12–40:38)	20
ГОЛ СЭДВҮҮД	22
Гэрээ Сахигч Бурхан (1:1–4:31).....	23
Ялагч Дайчин Бурхан (5:1–18:27)	26
Египетэд.....	26
Аяллын үед (13:17–18:27)	27
Гэрээний хууль өгөгч Бурхан (19:1–24:11)	29
Хамт буй Дайчин Бурхан (24:12–40:38)	31
ДҮГНЭЛТ	34
ХАМТРАГЧИД	36
ҮГСИЙН ТАЙЛБАР	38

Пентатух

Арван нэгдүгээр хичээл

Гэтлэл Номын Тойм

УДИРТГАЛ

Байгууллага болгон өөрчлөлтөд дундуур явж байдаг. Гэвч удирдлага нэг үеэс нөгөөд шилжих үед эдгээр өөрчлөлтүүд нь ихээхэн саад бэрхшээл болж болох юм. Чуулганыг үүсгэн байгуулагч нэгэн нь нас барах эсвэл гол бизнес эрхлэгч удирдагч нь тэтгэвэрт гарахад үлдэж буй удирдлага нь шинэ сорилтуудтай нүүр тулгардаг. Тиймээс бараг үргэлж гарч ирдэг нэг асуулт бий. Энэ нь Шинэ үеийн удирдагч нь өмнөх үеийн удирдагчдын нэн тэргүүнд чухалчлан баримталж байсан зүйлс, хийж хэвшсэн дадлыг хэр хэмжээгээр дагаж мөрдөх ёстой вэ? гэдэг нь юм.

Израилын ард түмэн Амлагдсан Газар орохоосоо өмнө яг ийм асуулттай тулгарсан байдаг. Удалгүй Мосегийн насан эцэслэх цаг нь болж, Израилчууд олон шинэ шинэ сорилтуудтай тулгарч байлаа. Тиймээс тэд Мосегийн өөрсдөд нь зориулж тогтоосон нэн тэргүүний чухал зүйлс, хийж хэвшсэн дадлыг хэр зэрэг дагаж мөрдөх ёстойгоо мэдэх хэрэгтэй байв. Тэд өөр замаар явах хэрэгтэй болох юм болов уу? Эсвэл тэд Мосегийн замаар үргэлжлүүлэх ёстой юу? Библийн хоёр дахь ном болох бидний одоо Гэтлэл гэж нэрлэдэг уг ном нь эдгээр болон үүнтэй төстэй асуултуудад хариулах зорилготой юм.

Энэ хичээлээрээ бид *Пентатухын* нэг хэсэг болох Библийн хоёр дахь номыг авч үзнэ. Бид үүнийг "Гэтлэл Номын Тойм" гэж нэрлэсэн. Энэ хичээлээр бид "Гэтлэл" анх бичигдэх үед ямар утгатай байсан, мөн үүнийг бид өнөөгийн амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар илүү гүнзгий судлах болно. Үүний тулд бид хэд хэдэн үндсэн асуудлыг шинжлэх болно.

Бидний хичээл гурван үндсэн хэсэгт хуваагдана. Нэгдүгээрт, бид Гэтлэлийг судлахдаа анхаарах шаардлагатай зарим зүйлийг авч үзэх болно Хоёрдугаарт, бид номын бүтэц, агуулгыг судлах болно. Гуравдугаарт, бид Гэтлэлийн зарим голлох сэдвүүдийн талаар ярилцана. Эхлээд анхаарах шаардлагатай зарим зүйлсийг авч үзье.

АНХААРАХ ЗҮЙЛС

Христийн дагалдагчдын хувьд бид Гэтлэл ном нь Ариун Сүнсний онгодоор бичигдсэн учир Бурханы Үг мөн гэдэгт итгэдэг нь зүйн хэрэг. Энэ итгэл үнэмшил нь бид энгийн номтой харьцаж байгаа биш юм гэдгийг бидэнд сануулдаг. Гэтлэл нь Бурхан Өөрийн ард түмэндээ өгдөг ариун нандин Бичвэр юм. Тиймээс Христийн дагалдагчид тул энэ ном өнөөдөр та бидний хувьд дагах ёстой эрх мэдэл билээ. Гэвч үүний хажуугаар Бурхан олон мянган жилийн өмнө амьдарч байсан хүмүүст энэ номыг анхлан өгсөн гэдгийг бид хэзээ ч мартаж болохгүй. Тиймээс бид өөрсдийн орчин үеийн хэрэгжүүлэлтээ уг номыг анх бичсэн зорилгод нийцүүлэх нь зүйтэй.

Бид Гэтлэл номыг үзэхдээ анхаарах шаардлагатай дөрвөн өөр зүйлсийг танилцуулах болно. Эхлээд бид үүний анхны бичээчийн талаар ярилцах болно. Уг номыг хэн бичсэн бэ? Хоёрдугаарт, бид энэ номыг хэзээ, хаана бичсэн талаарх нөхцөл байдлыг судлах болно. Гуравдугаарт, бид Гэтлэлийн анхны утгыг нэгтгэн дүгнэх болно. Дөрөвдүгээрт, орчин үед уг номыг хэрэгжүүлэхэд эдгээр нь биднийг хэрхэн чиглүүлдэг болохыг авч үзэх болно. Эхлээд Гэтлэлийн бичээчийн талаар үзэцгээе.

БИЧЭЭЧ

Гэтлэлийн бичээчийн тухай асуудал нь ерөнхийдөө Пентатухын бичээчийн талаарх урт, төвөгтэй маргааны нэг хэсэг болдог. Харин энэ хичээлээрээ бид уг мэтгэлцээний Гэтлэлд хамаарах цөөн хэдэн зүйлийг авч үзэх болно.

Гэтлэлийг өнгөц унших төдийд л Мосе энэ номын агуулгад ихээхэн нөлөөлсөн болохыг бид мэдэх болно. Гэтлэл номын ихэнхийг Бурхан Синаи Уулан дээр Мосед шууд илчилсэн гэдгийг уг ном өөрөө дахин дахин тунхагладаг. Үүнд Арван Хууль, Гэрээний Ном, Израилын асрын зааврууд зэрэг багтана.

Гэхдээ бид Пентатухын бусад хичээлүүдээрээ ихэнх шүүмжлэгч эрдэмтэд Мосег бичээч нь гэдгийг үгүйсгэсэн байдгийг үзсэн. Тэд Пентатухын теологи, тэр дундаа Гэтлэл нь Мосегийн үеийнх гэхийн аргагүй тун боловсронгуй байна гэж маргадаг. Харин тэд уг номыг МЭӨ 6-р зуунд болсон Вавилоны цөллөг дуусахаас өмнө бүрэн бичигдэж дууссан байх боломжгүй хэмээн батлах гэдэг.

Хэдий эдгээр шүүмжлэлт хандлагууд өргөн тархсан боловч цаад түүхэн болон теологийн таамаглалууд нь зөвхөн таамаг төдий бөгөөд тун найдваргүй байдаг. Түүнчлэн, эвангелийн үзлээр авч үзвэл бид Бичвэрүүдэд байдаг эрх мэдэл бүхий гэрчлэлийг дагах нь амин чухал байдаг. Хуучин Гэрээний бичээчид, Христ ба Түүний элч нар, эш үзүүлэгчид бүгд Мосе Пентатухыг бүхэлд нь, тэр дундаа Гэтлэл номыг ч бичсэн гэдэг үзлийг санал нэгтгэйгээр баталсан байдаг.

Одоо эвангелийн итгэгчид Мосег уг номын "үндсэн", "жинхэнэ" буюу "гол" зохиогч нь мөн гэснээрээ Мосег бичээч нь гэсэн итгэл үнэмшлийг баталгаажуулдаг. Энэ нь Мосе зүгээр л суугаад, Гэтлэлийн бүх үгсийг өөрийн гараар бичсэн гэсэн үг биш юм. Харин Мосе өөрийнх нь төрөлт болон бага настай холбоотой үйл явдлуудаас бусад номд дурдагдсан бүх үйл явдлын найдвартай нүдэн гэрч байсан. Тэрээр тухайн үеийн үндэстний удирдагчдын заншлыг дагаж, өөрийн удирдлага дор гүүш эсвэл бичээч нарыг ажиллуулж, өөрөө чиглүүлэг өгч бичүүлсэн харагддаг. Гэсэн ч, юутай ч Гэтлэл нь Мосегийн өдрүүдэд Ариун Сүнсний онгодоор бичигдсэн гэдэгт бид итгэлтэй байж болно.

Гэтлэл номыг хэн бичсэн бэ гэдэг нь маш чухал асуулт. Бид уг номыг уншиж, энд тэмдэглэсэн үйл явдлын түүхийг нухацтай авч үзэх юм бол үүнийг Мосе бичээгүй гэх шалтгаан байхгүй юм. Уг номд Мосе Бурханы төлөөлөн яригч гэж дүрслэгдсэн байдаг. Пентатухын үйл явдлын туршид тэрээр үнэхээр онцгой төлөөлөгч байсан. Бурханы ард түмний түүхийн туршид Есүс Өөрөө ирэх хүртэл түүн шиг Бурхантай ойр дотно эш үзүүлэгч байгаагүй

хэмээдэг. Мөн тэрээр Бурханыг маш ойр дотно мэддэг байсан тул хүн найзтайгаа ярилцдаг шиг Түүнтэй нүүр тулан ярилцаж, хүмүүст зориулсан Бурханы төлөөлөгчийн хувьд маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн Хуучин Гэрээ нь Пентатухын нэг хэсэг болох Гэтлэлээр үргэлжлэхдээ үүнийг Мосегийн Тора хэмээн тодотгож, хүмүүсийг өдөр шөнөгүй тунгаан бясалгахыг уриалдаг. Тиймээс Мосе бол номын бичээч нь мөн гэсэн санааг агуулж байгаа юм. Тэгээд цаг хугацаа өнгөрөхөд зарим нэг газрын нэрс, хэлзүйн дүрмийн хэлбэр зэрэгт өөрчлөлт сайжруулалт хийгдсэн харагддаг. Эдгээр нь мэдээж Сүнсний онгодоор эш үзүүлэгчдийн гараар хийгдсэн юм. Гэхдээ, тийм ээ, Гэтлэл ном нь угтаа Мосегийн гараар, Мосегийн хэв маягаар бичигдсэн л гэсэн үг... Тиймээс Мосе Израил дахь Бурханы гол төлөөлөн яригч, төдийгүй номын зохиогч, номын бичээч гэж дүрслэгдсэн байдаг.

- Проф. Томас Эггер

Мосегийн бичээч мөн эсэх талаарх эдгээр үзлүүдийг харгалзан авч үзсэн тул одоо бид Гэтлэл бичигдэх болсон нөхцөл байдал, цаг үеийн талаар анхаарах шаардлагатай зарим зүйл рүү орцгооё.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Өргөн хүрээнд харвал Гэтлэл 3:1–4:31 дээр шатаж буй бутны дэргэд өөрийг нь дуудсан дуудлагаас Дэд хууль 34:1-12-д буй Моабын талд нас барах хүртэлх хугацааны хоорондох аль нэг үед Мосе Гэтлэлийг бичсэн. Гэхдээ нотлох баримт үүнээс илүү нарийн тодорхойлох боломжийг бидэнд олгодог. Израилыг Амлагдсан Газрын хил дээр буудаллаж байх үед энэ ном дууссан байсныг Гэтлэлийн дор хаяж хоёр эшлэл бидэнд харуулдаг. Гэтлэл 16:35-р эшлэлийг хамтдаа харцгаая. Энд:

“Израилын хөвгүүд хүн оршин суудаг газар очих хүртэл дөчин жил манна иджээ. Канаан нутгийн хязгаарт очих хүртэл тэд маннаг идсэн билээ” (Гэтлэл 16:35).

Мэдээж эдгээр үйл явдлууд нь Гэтлэл ном дуусахаас өмнө болсон нь ойлгомжтой. Тиймээс Израил аль хэдийн "дөчин жил" тэнүүчилсэн болохыг бид мэднэ. Тэгээд тэд “суурин газар” буюу “Канааны хязгаарт” ирсэн байв.

Эцсийн тэмдэглэлийг бичсэн цаг хугацааг бид Гэтлэл 40:38 дээрээс цухас харж болно. Энд:

“Учир нь бүх аян замынх нь туршид Израилын бүх гэрийн нүдэн дээр ЭЗЭНий үүл өдөр нь асрын дээр байж, шөнө нь түүн дээр гал үзэгддэг байв” гэжээ (Гэтлэл 40:38).

Энэ эшлэлд “бүх аян замынх нь туршид” асрын дээр Бурханы сүр жавхлантай оршихуй байгааг дурдсан болохыг анзаарч байна уу? Энэ түүхэн тэмдэглэл нь Мосе

Гэтлэл номыг амьдралынхаа сүүлчийн өдрүүдэд дуусгасан гэдгийг харуулж байна. Тэрээр Израилчууд дөчин жил тэнүүчилж дуусаад Моабын талд ирсний *дараа* бичжээ.

Тэгэхлээр бид Гэтлэл номын бичээч болон нөхцөл байдлын талаар анхаарах шаардлагатай хэд хэдэн зүйлсийг авч үзлээ. Одоо тэгвэл түүний анхны утга санааг нэгтгэн дүгнэх болно. Бурхан яагаад Гэтлэл номыг Мосегоор бичүүлсэн бэ? Мосе Моабын талд буй анхны сонсогчид болох Израилчуудад чухам юуг хэлэхийг зорьж байв?

АНХНЫ УТГА

Мосе Хуучин Гэрээнд байнга дурдагддаг хэд хэдэн ерөнхий зорилготой байсныг бид анхнаас нь анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, Гэтлэл нь Израилыг Бурханаа байнга магтан, мөргөхөд хүргэх учиртай магтуу дууны шинжтэй байдаг. Гэхдээ энэ нь бас теологийн шинжтэй. Яагаад гэвэл энэ нь Бурханы тухай үнэнийг дахин дахин тайлбарладаг. Мөн Израил үндэстний амьдралыг хэлбэршүүлэн, зохион байгуулалтад оруулах зорилготой байсан гэдэг утгаараа уг ном нь бүхэлдээ улс төрийн шинжтэй байдаг. Энэ нь бас худал үзэл бодлыг хатуу эсэргүүцдэг тул мэтгэлцээний шинжтэй байдаг. Мөн Израил хэрхэн Бурханыг дуулгавартай дагахыг илчилсэн байдаг учраас ёс суртахууны шинжтэй юм. Түүнчлэн энэ нь Бурханд үнэнч байхыг урамшуулж, үнэнч бус байдлаас сэрэмжлүүлдэг гэдэг утгаараа зоригжуулах шинжтэй байдаг. Эдгээр болон бусад ижил төстэй зорилгууд нь Гэтлэл номыг бүхэлд нь хэлбэршүүлсэн харагддаг.

Гэтлэлийн дээрх хийгээд бусад онцлогууд нь Библийн хэд хэдэн номтой ижил төстэй байдаг боловч Мосед Гэтлэлийг бичих онцгой чухал зорилго байсан. Уг нэгдмэл зорилгыг дараах байдлаар дүгнэх нь тустай:

Гэтлэл ном нь анхны үеийнхний дээгүүрх тэнгэрээс тогтоож өгсөн Мосегийн эрх мэдлийг дэмжсэн байдаг. Энэ нь хоёр дахь үеийнхнийг ч Мосегийн энэхүү эрх мэдлийг хүлээн авахад чиглүүлэх зорилготой байжээ.

Энэхүү дүгнэлт нь Гэтлэлийн анхны утгыг ойлгоход туслах гурван хүчин зүйлийг хөндсөн болно. Нэгдүгээрт, номын ихэнх хэсэгт гэтлэлийн эхний үеийнхний *тухай* бичсэн байдаг боловч үүнтэй зэрэгцэн уг номыг хоёр дахь үеийнхэнд ч *зориулж* бичсэн гэдгийг бидэнд сануулж байна.

Гэтлэл номыг уншсан хүн болгон ихэнх хэсэгт нь Мосе Израилыг Египетээс гаргах үед тохиолдсон үйл явдлуудыг өгүүлдэг гэдгийг мэднэ. Бид энэ цаг үеийг түүхийн хувьд “өмнөх ертөнц” гэж нэрлэдэг. Хэдий тийм боловч Гэтлэл нь эхний үеийнхний буюу “өмнөх ертөнц”-ийн талаар хэлж буй бүхэн нь “тэдний ертөнц” гэж нэрлэж болох *хоёр дахь* үеийнхэнд хандан өгүүлэхээр зохион байгуулагдсан байв.

Эртний Израилчуудаас маш цөөхөн хүн л уншиж чаддаг байсныг тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс бид хоёр дахь үеийн “уншигчдын” тухай ярихдаа эрэгтэй, эмэгтэй, хүүхэд бүр Гэтлэл номын хуулбарыг олж аваад, өөрсдөө шууд л уншихдаг байсан гэж хэлээгүй юм. Эсрэгээрээ Хуучин Гэрээний бусад хэсгүүдийн нэгэн адил

Мосе Гэтлэл номыг үндсэндээ Израилын *удирдагчдад* зориулж бичсэн. Иошуа, овгийн ахлагчид, шүүгчид, тахилч нар болон левичүүд нь Гэтлэл номын гол уншигчид байжээ. Номын агуулгыг Израилын үлдэгсдэд хүргэж, тайлбарлах нь эдгээр удирдагчдын хариуцлага байв. Ийм учраас Гэтлэл нь хоёр дахь үеийнхэнд тулгараад байсан асуудлуудад шууд хандан, авч үзсэн байдаг.

Мосегийн ихэнх анхаарал нь хоёр дахь үеийнхэнд буюу “тэдний ертөнцөд” далд байдлаар хандсан байдгийг анхаарах нь чухал. Гэсэн хэдий ч, хоёр дахь үеийнхэн Мосег “тэдний ертөнц”-ийг бодож бичсэн гэдэгт итгэлтэй байхын тулд ихэвчлэн тэргүүн эгнээнд шилждэг. Бид өмнө дурдсанчлан Гэтлэл 16:35 ба 40:38 нь хоёулаа хоёр дахь үеийг заадаг. Нэмж дурдахад Гэтлэл 6:13-27 дээрх угийн бичиг нь Аароны ач хүү Финехаст хамаарна. Мөн бусад хэд хэдэн багц эшлэл нь хоёр дахь үеийнхэнд онцгой хамааралтай асуудлуудыг хөндсөн болохыг бид дараа нь харах болно. Эдгээр болон үүнтэй төстэй эшлэлүүд нь Мосе энэ номыг бичихдээ гэтлэлийн эхний болон хоёр дахь үеийг харгалзан үзсэнийг харуулж байна.

Мосегийн Гэтлэлийг бичих болсон анхны зорилгын талаарх бидний дүгнэлтийн хоёр дахь тал бол “эхний үеийнхний” тухай хэлсэн бүх зүйл нь “хоёр дахь үеийнхнийг *чиглүүлэхийн тулд* бичигдсэн гэх явдал юм. Өөрөөр хэлбэл, Мосе Гэтлэлийг хоёр дахь үеийнхэн нь Бурханд үйлчлэхдээ сахих ёстой бүрэн эрх мэдэлтэй ном болгон бичсэн гэсэн үг.

Бид Гэтлэл номыг унших үед Мосе өөрийн түүхэн тэмдэглэлээ хоёр дахь үеийнхэнд хамааралтай болгохын тулд тун анхааралтай зохион байгуулсан гэдэг нь тодорхой харагддаг. Канааны хил дээр түүнтэй хамт буудалласан хүмүүст хандахын тулд Мосе эхний болон хоёр дахь үеийнхний олон ялгаанд нарийвчлан анхаарч хандах хэрэгтэй болсон. Тэд өөр өөр цаг үе, газар нутагт амьдарч, өөр өөр сорилтуудтай тулгарсан гэдгийг тэр мэддэг байв. Тиймээс Мосе тэдний хоорондын холбогдох цэгүүдийг тодруулахын тулд Гэтлэлийн хэсэг бүрийг чадварлаг загварчилсан. Эдгээр холболтууд нь түүний анхны уншигчдад өөрсдийн болон өвөг дээдсийнхээ хоорондох зайг арилгах боломжийг олгосон.

Түүхэн Нөхцөл

Мосе номынхоо эрх мэдлийг анхны уншигчдадаа тодорхой болгох гурван үндсэн холбоосыг бий болгосон. Түүний хамгийн энгийн холбоос нь түүхэн суурь нөхцөлүүдийг агуулсан байв. Эдгээр багц хэсгүүд нь анхны уншигчдын онцгой эрх, үүрэг хариуцлагын түүхэн үндэс дээр төвлөрч байв.

Гэтлэл 3:8 дээрх Бурханы Израилд өгсөн амлалт нь энэхүү амлалтын биелэлттэй холбогддог түүхэн суурь нөхцөлийн нэг хэлбэр юм. Энэ эшлэлд Бурхан Израилыг Египетээс гаргаж, “сүү балаар бялхсан сайхан уудам нутагт” авчрахаа амласан. Энэ зөгнөл нь Мосегийн уншигчдад чухал хамаатай байв. Учир нь тэд энэ амлалтын биеллийг харахын даваан дээр байлаа.

Өөр нэг түүхэн нөхцөл байдлыг бид Бурханы эхний үеийнхэнд өгсөн зарлигууд болон хоёр дахь үеийнхний залгамжилсан үүрэг хариуцлагаас харж болдог. Жишээлбэл, Гэтлэл 20:1-17 дээр Мосе Бурхан цөл дэх эхний үеийнхэнд Арван Хуулийг хэрхэн өгсөн тухай дурддаг. Энэ үйл явдал нь хоёр дахь үеийн ёс суртахууны үүргийн үндэс болсон байдаг.

Загварууд

Түүхэн нөхцөл байдлаас гадна Мосе уншигчдад үлгэр дуурайл болох эсвэл татгалзах ёстой түүхэн загваруудыг ч мөн өгсөн. Мосе ийм төрлийн холбоо бий болгохын тулд эхний болон хоёр дахь үеийн уншигчдын хоорондох ижил төстэй байдлыг тэмдэглэсэн байдаг.

Олон хэсэгт Мосе иймэрхүү ижил төстэй байдлуудыг ашиглаж, анхны уншигчдынхаа татгалзах ёстой сөрөг загваруудыг бичсэн. Жишээ нь, Гэтлэл 15:24, 16:2-12, 17:3 дээр Синаи руу хийсэн аяллын үеэр Израилын давтан үйлдсэн тэрслэл гомдол нь хоёр дахь үеийнхний татгалзах ёстой сөрөг загваруудыг илтгэн харуулдаг.

Эсрэгээр, Мосе бас уншигчдадаа үлгэр дуурайл үзүүлэх эерэг загваруудыг ч өгсөн. Тухайлбал, Гэтлэл 36:8-38 дээр байдаг асар барих тухай Бурханы зааврыг Израил дагаж мөрддөг. Энэ нь хоёр дахь үеийнхэн дараа нь асарт Бурханд үйлчлэхдээ дагах ёстой эерэг үлгэр жишээг илэрхийлсэн.

Мөн Мосе эерэг ба сөрөг чанарын аль алиныг нь харуулсан холимог загварыг ч гаргаж тавьсан байдаг. Зөвхөн нэг жишээ дурдахад, Гэтлэл 7:8-13-т Аарон Бурханд дуулгавартай байж, таягаа Фараоны өмнө хаясан. Түүний дуулгавартай байдал нь Израилыг Египетээс чөлөөлөхөд хөтөлсөн. Гэвч 32:1-35-д тэрээр ард түмэнд алтан тугал хийсэн ба түүний энэхүү дуулгаваргүй байдал нь Израилыг хатуу шийтгэхэд хүргэв. Энэ нь хоёр дахь үеийн уншигчдад даган дуурайх, бас татгалзах ёстой холимог үлгэр загварыг өгсөн.

Урьдач зөн

Гуравдугаарт, цөөхөн хэдэн тохиолдолд Мосе хоёр дахь үеийн уншигчдадаа түүхэн зөгнөлүүд буюу урьдчилсан зөн маягаар бий болох үйл явдлуудыг дүрсэлсэн байдаг.

Орчин үеийн кино, уран зохиолын нэгэн адил Библийн хүүрнэл ч гэсэн бичээчид нь битүү дохио ашигладаг. Гэтлэл номын эхэн үед Мосе Египетийг орхисны дараа худаг дээр ирж, Иетрогийн охидыг хорон санаат хоньчдоос аварч, чөлөөлсөн тухай сайн жишээ бидэнд бий. Мөн уг текстэд Мосег яг л чөлөөлөгч мэт дүрд байгаагаар дүрсэлж байна. Тэгэхлээр энэ нь Бурхан түүгээр дамжуулан юу хийхээ зөгнөсөн хэрэг байв. Тэрээр Египет рүү удахгүй явж, Бурханы хүмүүсийг боолчлолоос чөлөөлөх болно.

- Др. Роберт Б.Чишолм, Жр.

Энэ төрлийн холбоос нь Хуучин Гэрээний бусад номуудын адил Гэтлэлд тийм ч их тохиолддоггүй. Гэвч зарим тохиолдолд Мосе өнгөрсөн үеийн үйл явдлуудыг анхны уншигчдынхаа туршлагад бараг төгс тохирсон байдлаар дүрсэлсэн. Эдгээр зөгнөлүүд нь хоёр дахь үеийнхний өдрүүдэд ч түүх давтагдаж

байсныг илтгэдэг. Жишээлбэл, Гэтлэл 13:18-д Израилчууд “Египет газраас байлдааны бэлтгэлтэй гарлаа” гэсэн байдаг. Эхний үеийн энэхүү цэргийн зохион байгуулалт нь хоёр дахь үеийн цэрэг арми нь амласан газрыг эзлэхээр орохдоо хэрхэн бэлтгэгдсэн байсныг урьдаас зөгнөн илэрхийлж байна.

Үүнтэй адилаар Гэтлэл 40:34-38-д асрын үйл ажиллагаа хэвийн болмогц Бурхан ард түмнээ дагуулан явахдаа утаа, гал дунд үзэгдсэн гэж тэмдэглэсэн байдаг. Энэхүү түүхэн бодит явдал нь 40 орчим жилийн дараа Бурханы оршихуй хоёр дахь үеийн уншигчдыг хэрхэн удирдахыг ч урьдаас зөгнөж байлаа.

Бидний саяхан харсанчлан, Мосе эхний үеийнхний түүхийг тэмдэглэхдээ хоёр дахь үеийнхэнд тухайн үеийн түүхэн нөхцөл, загвар, зөгнөл болгохын тулд хэлбэршүүлжээ. Тэднийг Бурханд үйлчлэхэд чиглүүлэхийн тулд тэрээр үүнийг хийсэн юм. Гэхдээ энэ бүхэн биднийг Гэтлэлийн анхны утгын дүгнэлтийн гурав дахь, магадгүй хамгийн чухал элемент рүү авчирна. Гэтлэл ном нь юуны түүрүүнд Мосегийн эхний үеийнхнийг удирдах тэнгэрлэг эрх мэдлийг нь зөвтгөх зорилготойгоор бичигдсэн. Ингэснээр хоёр дахь үеийнхэн нь өөрсдийн амьдрал дахь Мосегийн бүрэн эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх учиртай байлаа.

Тэгэхээр Аарон Гэтлэл номд Мосегийн хажууд байнга гардаг гэдгийг дурдах нь чухал. Хэдий энд Аароны тухай өгүүлдэг ч Гэтлэлийн бараг бүх хэсэг нь хоёр дахь үеийнхэнд Мосегийн эрх мэдэл хүчинтэй хэвээр гэдгийг сануулсаар байдаг. Тэд Мосегийн теологийн үзэл, түүний ёс суртахууны зарчмууд, үндэсний бодлого зэрэгт захирагдах ёстой байв. Энэ хичээлээрээ бид энэ сэдэв хэр өргөн хүрээтэй болохыг нарийвчлан үзэх болно. Гэхдээ яг энэ мөчид бид уг ном нь Мосегийн ач холбогдол болон түүний Израилыг удирдах эрх мэдлийг онцолсон хоёр арга замыг товч үзэх болно.

Нэгдүгээрт, Гэтлэлийн өрнөлийн гол тайзыг Мосе эзэлсэн байгааг харахад тийм ч хэцүү биш. Бүр нарийвчлан үзвэл, Гэтлэлийн эхний хоёр бүлэгт Мосег шууд танилцуулдаггүй. Гэвч бид Гэтлэл 2:10 дээрээс түүний нэрийг мэдээд зогсохгүй уг номд тохиолдож буй бүхэн Мосетэй ямар нэгэн байдлаар нягт холбоотойг олж харна. Бурхан ард түмнээ Египетээс чөлөөлөхөд бэлэн болох үедээ Мосег дуудсан. Египетчүүдийн дээр буулгасан бүхий л ер бусын шүүлтэд Мосе чухал үүрэг гүйцэтгэсэн. Бурханыг дуулгавартай дагаж, түүнийг усан дээгүүр гараа сунгахад тэнгис хуваагдсан. Бурхан ард түмнээ Египетээс Синаи Уул руу хөтлөх үед Мосе тэдний удирдагчаар үйлчилсэн. Бурхан Мосегоор дамжуулан Израилтай гэрээ байгуулсан. Мосе Бурханы өмнөөс тэдэнд Гэрээний ном болон Хуулийн хавтангуудыг өгөв. Бурхан Мосед асрын тухай зааварчилгааг ч өгсөн. Синаи Уулын бэлд Израил хиймэл шүтээн шүтэх үед ч Мосе Бурханд үйлчилсээр байв. Мөн Мосе асар барих ажлыг удирдсан байдаг.

Хоёрдугаарт, Гэтлэл ном нь Мосегийн Израилын дээгүүрх эрх мэдлийг нь дахин дахин онцолдог. Энэ ном нь Израилчууд Мосег өөрсдийн удирдагч гэж хүлээн авах эрх мэдлийг нь үгүйсгэн маргалдаж байсныг Гэтлэл 2:14; 5:21; 15:24; 16:2 ба 3; мөн 17:2 зэрэг эшлэлүүдэд өгүүлдэг. Харин бусад тохиолдолд Израилчууд өөрсдийнх нь дээр байх Мосегийн эрх мэдлийг хүлээн авсан харагддаг. Энэ тухай Гэтлэл 4:31; 14:31; болон 20:19 гэх мэт эшлэлүүдээс харж болно. Мөн бид Гэтлэл 6:1-8 болон 10-13; 24:2; мөн 34:1-4 зэрэг эшлэлүүдээс Бурхан Өөрөө Мосег Израилын эрх мэдэлтэй удирдагч болгон тосолсон гэдэг баталгааг олж уншина.

Ганцхан жишээ болгож Синаи Уулан дээрх теофани буюу Бурхан Мосед Өөрийгөө харуулах талаараа хэрхэн тайлбарлаж байгааг Гэтлэл 19:9 дээрээс харцгаая. Энд:

“Үзэгтүн, чамтай Миний ярихыг ард түмэнд сонгож, тэднийг чамд үүрд итгүүлэхийн тулд Би чам руу өтгөн үүлээр очно гэв” гэжээ (Гэтлэл 19:9).

Энэ багц эшлэлийн тэмдэглэн өгүүлснээр Бурхан "өтгөн үүлээр" Синаи Ууланд үзэгдэж, Мосетэй ярьж байгаагаа Израилчуудад сонгосон нь "[Мосед] үүрд итгүүлэхийн тулд" байсан аж. Бидний харж байгаачлан энэ эшлэл нь Гэтлэл номын бичигдсэн хамгийн чухал шалтгаанд анхаарал хандуулж байна. Гэтлэл ном нь Мосегийн Израилыг удирдах үргэлжилсээр буй эрх мэдлийг зөвтгөсөн.

Эвангелийн итгэгчид Гэтлэл зэрэг өөр бусад номыг хар аяндаа л Бурхан төвт байдлаар харах хандлагатай байдаг. Энэ нь тухайн номын бүхий л зүйлийг Бурханы эргэн тойронд төвлөрүүлж, бичигдсэн бүгд нь Бурханы тухай гэж үздэг гэсэн үг л дээ. Гэвч бодит байдал дээр та Гэтлэл номыг унших юм бол та тэдэн шиг тийм сэтгэгдэлтэй байж чадахгүй. Мэдээж хэрэг Бурхан чухал. Тэрээр олон талаар гол дүр нь мөн. Наад зах нь л гэхэд Гэтлэлд өгүүлж буй түүхийн туршид Тэрээр ажиллаж, удирдсаар байдаг шүү дээ. Тэр бол Израилыг Египетээс чөлөөлөгч Нэгэн. Тэр бол хуулийг өгөгч. Тэр бас асрын Эзэн мөн. Гэхдээ үүнтэй зэрэгцэн Гэтлэл ном дээрх үйл явдлуудын тухай өгүүлсэн утга зохиолын дүрслэлийг харвал та тун хачирхалтай зүйлийг олж мэдэх болно. Миний бодлоор энэ нь ч надад үнэн санагддаг. Яагаад гэвэл Гэтлэл номын туршид нэг тохиолдлыг л эс тооцвол Бурхан яг Өөрөө ямар нэг зүйл хийгээгүй байдаг. Тэрээр зөвхөн Мосегоор дамжуулан ажиллаж байсан. Мосегоор дамжуулан биш гагцхүү Өөрөө хийсэн тэр нэг тохиолдол нь эхний бүлэгт эх баригчдыг ерөөсөн явдал юм. Тэгэхлээр Гэтлэл номоос бид Бурхан Израилын төлөөх агуу үйл хэргээ гүйцэлдүүлдэг ч Мосе тэнд нь үргэлж байдаг. Учир нь Бурхан түүгээр дамжуулан ажлаа хийдэг байсан юм. Үүний шалтгаан нь Мосегийн амьдрал дуусах дөхөж, Израилыг орхих гэж байгаа ч Бурхан Израилыг орхихгүй гэдэгтэй холбоотой. Иймээс үнэндээ Гэтлэл номыг унших үед энэ нь Моабын талд бүрэн бичигдэж дууссан бөгөөд Мосе Израилыг орхих гэж байгаа гэдгийг та олж харах болно. Энэ бүгдийг мэдээд Гэтлэл номыг харвал бид Израилчууд дараах асуултуудыг асууж байгаа нь ямар учиртайг мэдэх болно. Тэд “Хэн биднийг удирдах ёстой юм бэ? Тэд яаж удирдах ёстой юм бол? Тэд ямар зүйлсийг тэргүүнд тавих ёстой вэ? Мосе биднийг орхих гэж байгаа энэ үед бид ямар эрх мэдлийг дагах хэрэгтэй вэ? Зэргээр асууж байлаа. Харин Гэтлэл ном нь яг л ийм төрлийн асуултуудад хариулахаар зохион байгуулагдсан юм. Үнэндээ Бурхан Израилыг Египетээс чөлөөлсөн нь үнэн боловч Тэрээр Мосегоор дамжуулан ийнхүү

чөлөөлсөн. Тийм ээ, Бурхан Израилд хуулийг өгсөн, гэвч Бурхан Мосегоор дамжуулан хуулийг өгсөн. Тийм ээ, Бурхан Өөрийн ариун асраа өгсөн боловч Мосегоор дамжуулан үүнийгээ гүйцэтгэсэн. Эдгээр нь Гэтлэл номын онцолж буй зүйл мөн. Тиймээс Гэтлэл ном нь эхний үеийнхэнд юу болсон тухай түүхийг өгүүлснээр Мосегийн эрх мэдлийг хоёр дахь үеийнхэнд ч баталгаажуулж, Бурхан Мосег ард түмний өмнө хэрхэн өргөмжилсөн тухай түүхийг өгүүлдэг. Тэрхүү өргөмжлөлийн улмаас тэрээр хэдийгээр өөд болох гэж байгаа ч гэсэн хоёр дахь үеийнхний өмнө өргөмжлөгдөх ёстой байлаа.

- Др. Ричард Л. Прагт, Жр.

Одоо бид Гэтлэлийн бичээч, нөхцөл байдал болон анхны утгатай холбоотой шаардлагатай зарим зүйлсийг хөндлөө. Тиймээс эдгээрийг орчин үед хэрхэн хэрэгжүүлэх талаар цөөн хэдэн тайлбар хийх хэрэгтэй. Өнөөдөр Христийн дагалдагчид бид энэ номыг хэрхэн хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?

ОРЧИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Гэтлэл шиг нарийн төвөгтэй номыг орчин үеийн амьдралд тоо томшгүй олон янзаар хэрэгжүүлж болно. Хүн бүр өвөрмөц бөгөөд өөр өөр амьдралын нөхцөлтэй байдаг гэдгийг бид мэддэг тул ингэж хэлж байгаа юм л даа. Үүнийг бид энэ хичээлийнхээ дунд хэсэгт удахгүй илүү анхааралтай авч үзэх болно. Гэхдээ одоо энэ нь бид Гэтлэлийг өнөөдөр амьдралдаа хэрэгжүүлэхдээ үргэлж санаж байх ёстой зарим ерөнхий зүйлсийг тэмдэглэн үзэхэд тусална.

Христийн дагалдагчдын хувьд Гэтлэл ном нь Бурханы Үг учраас бидний амьдралд хэрэгждэг гэдгийг бид мэднэ. Гэхдээ бидний болон анхны уншигчдын хооронд мэдэгдэхүйц ялгаанууд бий. Ийм учраас бидний орчин үеийн хэрэгжүүлэлтэд бидэнд удирдамж чиглүүлэг болох Шинэ Гэрээ рүү үргэлж эргэж очих ёстой. Шинэ Гэрээ нь Гэтлэл номоос 240 орчим удаа эш татах юмуу санаа дурдсанаар бидэнд удирдамжуудыг санал болгодог. Гэхдээ нэг Шинэ Гэрээний багц хэсэг онцгой тустай байдаг. Элч Паулын 1Коринт 10:1-5 дээр энэ тухай өгүүлсэн байдаг. Энд:

“Эцгүүд маань бүгд үүлэн доор байж, бүгд тэнгисийг гатлан гарч, бүгд үүл ба тэнгист Мосе руу баптисм хүртэж, бүгд адилхан сүнслэг хоол идэж, бүгд адилхан сүнслэг ундааг ууж байсан. Тэднийг дагаж байсан сүнслэг хаднаас тэд ундаалсан ба тэр хад нь Христ байв. Гэсэн ч тэдний олонх нь Бурханы таалалд нийцээгүй тул цөлд хиарсан юм” гэжээ (1Коринт 10:1-5).

Эндээс харахад Гэтлэл номд дурдсан хэд хэдэн үйл явдлын талаар Паул дурджээ. Харин багц эшлэл цаашаа яаж үргэлжилж байгааг одоо 1Коринт 10:11 эшлэлээс харцгаая. Энд:

“Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ” гэсэн байна (1Коринт 10:11).

Эдгээр эшлэлүүд бүгд Гэтлэл номыг Христийн дагалдагч бидэнд ач холбогдолтой гэдгийг тодорхой нотолж байна. Паул "энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон" гэв. Мөн тэдгээрийг "бидэнд сануулга болгон бичжээ." Гэтлэл зөвхөн "өмнөх ертөнц"-ийн талаар бичээд зогсохгүй мөн зөвхөн "тэдний ертөнц"-ийн тухай ч биш, мөн "манай ертөнц"-ийн тухай ч бичигдсэн гэдгийг ойлгоход Паулын үгс бидэнд тусалдаг. Үүнийг энэ хичээлийн нэр томъёогоор тайлбарлавал, Гэтлэл ном нь зөвхөн анхны уншигчдыг чиглүүлэхэд зориулагдан бичигдээгүй юм. Энэ нь мөн Христийн дагалдагч "бидний төлөө" зориулагдсан байв.

Христийн дагалдагчдын тэрхүү ертөнцийг элч хэрхэн дүрсэлснийг харъя л даа. Энд “үеийн төгсгөл тохиож буй бидэнд” гэсэн байна. "Төгсгөл" гэдэг нь *τέλος* (*telos*) гэх грек үгийн орчуулга бөгөөд ихэвчлэн "төгсгөл" эсвэл "зорилго" гэж хөрвүүлдэг. Түүхэн дэх Бурханы төлөвлөгөө Христ дотор төгсөж буюу зорилгодоо хүрч буй цаг үед Христигчид амьдарч байна. Теологийн нийтлэг нэр томъёогоор бол Есүсийг дагадаг бид түүхийн “эскатологийн” буюу “эцсийн” цаг үед амьдарч байна.

Паул юу бодож байсныг ойлгохын тулд бид Христэд итгэх авралын итгэлийг хүлээн авснаараа том аяллын нэг хэсэг болдог гэдгээ ухамсарлах ёстой юм. Бид Египетийн боолчлол, дарангуйллаас Бурханы Амласан Газар дахь эрх чөлөө, ерөөлд хүрэх Израилын аялал болон Мосегийн "эцсийн өдрүүд"-д бодитойгоор оролцдог.

Шинэ Гэрээ бүхэлдээ эскатологийн эрин үе буюу Христ доторх сүүлчийн өдрүүд нь гурван үндсэн үе шаттайгаар өрнөдөг гэж заадаг. Тиймээс, Мосе болон Израилын аяллын энэхүү эцсийн шат нь Христийн дэлхий дээрх үйлчлэлээрээ хаанчлалын *эхлэл үеийг* авчирснаар эхэлсэн гэж Библи үздэг. Мөн Гэтлэл ном дахь Мосе ба Израилын аялал нь эдгээр эцсийн өдрүүдэд чуулганы түүхийн туршид итгэгчид хаанчлалын *үргэлжлэх үед* Христтэй нэгдэх үед үргэлжилсээр байна. Эцэст нь, яг л Мосе ба Израилчууд Египетээс Амласан Газар руу аялсан шиг, Христ доторх бидний аяллын сүүлчийн өдрүүд Түүний хаанчлал бүрэн төгс болох үед дуусаж, Түүний гайхамшигт эргэн ирэлтээр бид шинэ тэнгэр, шинэ газарт орох болно.

Тиймээс 1Коринт 10-р бүлэгт дурдсанчлан Христ доторх эцсийн өдрүүдийн эхлэл, үргэлжлэл болон бүрэн төгс болох тэрхүү үеийн гэрэлд Гэтлэл номын сэдэв бүрийг авч үзэн, орчин үеийн Христигчид бид амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Бид эдгээрийг хэд хэдэн аргаар холбож болно. Жишээ нь, Синаи Ууланд Бурханы Мосетой байгуулсан гэрээг Израил хүлээн авсан гэж Гэтлэл бидэнд хэлдэг. Үүнтэй адил аргаар Христигчид Христ дотор шинэ гэрээг байгуулдаг. Гэвч энэхүү шинэ гэрээ нь Христийн анхны ирэлтээр эхэлсэн, одоо үргэлжилж байгаа бөгөөд Христийн хоёр дахь ирэлтээр дуусах болно.

Өөр нэг жишээ авах юм бол Гэтлэл номд Мосегийн өдрүүдэд асарт Бурханы оршихуй байсан хэмээн дурддаг. Христ дотор Бурханы оршихуй бүр ч илүү агуу байдаг гэж Шинэ Гэрээнд заадаг. Есүс Өөрөө хаанчлалынхаа *эхлэл үед* бидний дунд оршин байсан Бурханы оршихуй байлаа. Хаанчлалын *үргэлжлэх үед* одоо Ариун Сүнс хувь итгэгчдийн дотор хийгээд чуулганд бүхэлд нь оршдог. Мөн түүхийн *бүрэн*

төгс болох үед шинэ бүтээлд Тэрээр оршиж, Бурханы сүр жавхлан бүхнийг дүүргэх болно.

Гэтлэл нь мөн Мосегийн өдрүүдэд Бурхан дайснуудаа ялсныг илчилдэг. Шинэ Гэрээн нь Христ нүгэл ба үхлийг ялсан гэдгийг заадаг. Христ анхны ирэлтээрээ Бурханы хүчирхэг дайчин болж дайсны ялагдлын эцсийн шатыг хэдийнээ эхлүүлсэн. Чуулган нь одоо сүнслэг дайнд Бурханы бүрэн хуяг дуулга өмссөнөөр Түүний арми болж, Христийг дагаж байна. Мөн Тэрээр сүр жавхлантайгаар буцаж ирэхдээ Бурханы дайснуудын эсрэг агаарын хүчний агуу дайнаа бүрэн дуусгах болно.

Нэмж дурдахад Гэтлэлд Израилчууд Амлагдсан Газар дахь өөрсдийн өвөө Бурханаас авахаар явж байсан. Энэ нь тэдний Бурханы захиргааг дэлхий даяар түгээх анхны алхам байсан юм. Христигтэгчид Христ дотор өвийг хүлээн авдаг гэж Шинэ Гэрээ заадаг. Христ хаанчлалынхаа эхлэл үед Өөрийн өвөө баталгаажуулсан юм. Өнөөдөр Христигтэгчид бид Ариун Сүнс дотор өөрсдийн өвийг урьдчилгаа болгон баяр хөөрийг эдэлсээр байна. Христ эргэн ирэхэд, Тэрээр, мөн Түүний доторх бид ч бүх зүйлсийг өвлөх болно.

Эдгээр болон бусад өргөн хүрээний холбоосууд Гэтлэл нь Мосегийн үргэлжилсээр буй эрх мэдэл Христийн доторх бидэнд ч хэрхэн хэрэгжсээр байгааг тодруулж өгдөг. Товчхондоо, Гэтлэл ном өөрийн анхны уншигчдадаа өөрсдийнх нь цаг үед Бурханы хийж байсан зүйлсийн улмаас Мосегийн эрх мэдэлд үнэнч байхыг уриалсан. Гэтлэл одоо биднийг Бурханы Христ дотор хийсэн, хийж байгаа, хийх бүхний улмаас Мосегийн эрх мэдэлд үнэнч байхыг бас уриалж байна.

Одоо бид Гэтлэл номын зарим шаардлагатай зүйлсийг нэгэнт хөндсөн тул энэ хичээлийн хоёр дахь гол сэдэв болох номын бүтэц, агуулга руу шилжих хэрэгтэй.

БҮТЭЦ БА АГУУЛГА

Гэтлэл ном нь олон янзын дүрүүд, нөхцөл байдал, үйл явдлууд зэргийг агуулсан дөчин бүлгээс бүрддэг. Бид хүүрнэл, дуу, угийн бичиг, жагсаалтууд, хуулиуд, ярианууд, залбирлууд, зааврууд зэрэг утга зохиолын олон төрлийн хэлбэрийг олж хардаг. Энэхүү олон хэсгээс бүрдсэн байдал нь заримдаа номын гол хэсэг, дэд ба туслах хэсгүүдийг хооронд нь ялгахад хэцүү болгодог. Тиймээс, Гэтлэлийг олон янзаар тоймлож болдог гэж хэлж болно. Гэхдээ номын анхны зорилгыг санах юм бол номын үндсэн бүтэц, агуулгыг ялган харах нь тийм ч хэцүү биш ээ.

Гэтлэл ном хоёр гол хэсэгт хуваагддаг. Эхний хагас буюу 1:1–18:27 нь Израилыг Египетээс чөлөөлж Синаи Ууланд хүргэсэн Мосе дээр төвлөрдөг. Хоёрдугаар хагас буюу 19:1–40:38 нь Синаи Уулнаас Канаан руу орохоор бэлтгэж байгаа Израил ба Мосетой холбогддог.

Эдгээр хоёр гол үндсэн хэсэг нь Гэтлэлийн хоёр дахь үеийнхний дээр ч үргэлжилсээр буй Мосегийн эрх мэдэлд хэрхэн төвлөрч байгааг бид тусгайлан авч үзэх болно. Ингээд Израилыг Египетээс чөлөөлж Синаи Ууланд хүргэсэн Мосегоос эхэлцгээе.

ЕГИПЕТЭЭС ЧӨЛӨӨЛӨГДСӨН НЬ (ГЭТЛЭЛ НЬ 1:1–18:27)

Мосе болон Израилын Египетээс чөлөөлөгдсөн явдал нь Израилыг чөлөөлөхөөс *өмнөх* Мосегийн эрх мэдлийг харуулснаар эхэлдэг. Бид үүнийг Гэтлэл 1:1–4:31 дээрээс харж болно. Дараа нь 5:1–18:27 дээр Мосе Израилыг чөлөөлөх *үеийн* үйл явдлуудыг голчлон өгүүлдэг. Эхлээд Израилыг чөлөөлөхийн өмнөх үйл явдлын талаар Гэтлэл бидэнд юу хэлснийг харцгаая.

Чөлөөлөлтөөс Өмнө (1:1–4:31)

Израилыг чөлөөлөхийн өмнөх үйл явдлуудыг хоёр хэсэгт хувааж болно. Нэгдүгээрт, Мосегийн төрөлт хийгээд хэрхэн өсөж торнисон талаар 1:1-р эшлэлээс эхэлж, 2:10 хүртэл үргэлжлэн өгүүлдэг. Үүний дараа бид 2:11–4:31 дээрээс Мосе Израилын удирдагч болж буйг унших болно. Тэгэхээр эхлээд хамтдаа Мосегийн төрж, өссөн талаарх түүхийг үзэцгээе.

Мосе төрж, өссөн нь (1:1–2:10). Энэ хэсэгт Мосе залуу насаа Египетийн хааны ордонд өнгөрөөсөн тул түүний эрх мэдлийн эсрэг гарч болох аливаа асуудлуудын тухай өгүүлсэн байдаг. Түүх эхлэх үед Фараон Израилын тоо нэмэгдэж байгаа тул бослого гаргахаас нь эмээдэг. Тэрээр Израилын хүн амыг барих гурван ухаалаг төлөвлөгөө боловсруулсан. Гэвч тэрээр хүнд хөдөлмөр ногдуулсан нь харин ч бүтэлгүйтсэн байдаг. Мөн Израилын хөвгүүдийг төрөх үед нь алахыг эх баригч нарт тушаасан нь ч бүтэлгүйтэв. Хамгийн гол нь Израилын хөвгүүдийг Нил мөрөнд живүүлэх тухай түүний тушаал ч бүтээгүй юм.

Эдгээр егөө нь цувран үргэлжилдэг. Гэвч хамгийн том егөөдөл нь Фараоны төрсөн охин Мосег Нил мөрнөөс аварснаар түүний сүүлчийн төлөвлөгөөг нурааж орхидог явдал юм. Дараа нь 2:10 дээр Фараоны охин Мосед "Би түүнийг уснаас гаргаж авсан юм" гэсэн утгатай нэр өгдөг. Тэгээд Египет хэлээр "Мосе" гэдэг нь "хүү" гэсэн энгийн утгатай байсан тул ихэнх хүмүүст Мосе хааны ордонд хамааралтай нэгэн байсныг илтгэж байв. Гэвч Фараоны охин Мосе гэдэг нэрийг сонгосон шалтгаанаа энэ нь еврей хэлээр *מֹשֶׁה* (*машах*) буюу "гаргаж авах" гэсэн утгатай үгтэй адил сонсогддог гэж тодорхой тайлбарласан. Тиймээс, Бурханд үнэнч Израилчуудын чихэнд Мосегийн нэр нь түүнийг Фараоны хүү гэж сонсогдоогүй юм. Харин энэ нэр нь Фараоныг тохуурхаж, Израилыг хорлох гэсэн Фараоны оролдлого хэрхэн бүтэлгүйтсэн болохыг сануулдаг аж.

Мосе удирдагч болсон нь (2:11–4:31). Израилын Египетээс чөлөөлөгдөхийн өмнөх үйл явдлуудын хүүрнэл нь Мосегийн төрж, өссөн түүхээр эхэлж, 2:11–4:31-т өгүүлэх тэрээр хэрхэн Израилын удирдагч болсон талаар үргэлжилдэг.

Гэтлэл 2:14 дээр Израилын нэгэн боол Мосетэй маргалдаж, "Хэн чамайг бидний дээрх захирагч, шүүгч болгосон юм бэ?" гэдэг. Энэ хэсэг бүхэлдээ Мосе хэрхэн Израилын эрх мэдэл бүхий удирдагч болсныг тайлбарласнаар энэ асуултад хариулсан байдаг. Израил хүний асуултын хариулт нь зургаан алхамт хиастик

бүтэцтэй байдаг. Энэ нь үндсэн хэсгийн өмнө болон хойно байрлах хэсгүүд нь хоорондоо зэрэгцсэн эсвэл харилцан тэнцвэртэй байдаг уран зохиолын бүтэц юм. Нэгдүгээрт, Гэтлэл 2:11-15-д буй Мосегийн Египетээс зугтсан явдал нь Израил боолыг өмгөөлж, Египет хүнийг алсан тул ийнхүү гэдгийг тайлбарласнаар түүнийг Израилын удирдагч хэмээн зөвтгөж байна.

Хоёрдугаарт, 2:16-22-т Мосе Мидиан хүмүүсийн гэр бүлтэй нэгдсэн. 22-р эшлэлд Мосегийн хүүгийн нэрийг “Гершом” гэж тэмдэглэсэн байдаг. Энд тайлбарласнаар энэхүү нэр нь "хүний нутагт цагаач болсон" гэсэн утгатай גֶרְשֹׁם (*гер шам*) еврей хэллэг шиг сонсогддог. Энэ нь Мосе Мидианчуудын дунд харь хүн шиг санагдаж байсныг илтгэж байв. Өөрөөр хэлбэл тэрээр жинхэнэ Израил хүн гэдгээ хэзээ ч мартаагүй юм.

Гуравдугаар хэсэг болох Гэтлэл 2:23-25-д Бурхан гэрээгээ дурсан санадаг тухай өгүүлдэг. Энэ хэсэгт Израилчууд тусламж гуйн хашхирсан бөгөөд Бурхан Израилын эцэг өвгөдөд өгсөн амлалтаа санасан тухай бий.

Дөрөв дэх хэсэг нь өмнөх хэсэгтэй харилцан уялдсан байна. 3:1–4:17 дээр Бурхан шатаж буй бутан дундаас Мосетэй ярьж, түүнд үүрэг даалгаврыг өгсөн тухай өгүүлдэг. Энд Бурхан Израилыг Египетээс гаргаж, Амлагдсан нутагт нь авчрахаар Мосег дуудсан нь эцэг өвгөдтэй нь байгуулсан гэрээгээ эргэн санасан гэдгийг нь харуулж, түүнийг удирдагч гэдгийг баталдаг.

Тав дахь хэсэг буюу Гэтлэл 4:18-26-р эшлэл нь Мосегийн Мидиан хүмүүстэй гэр бүл болон амьдарч байсан хоёр дахь хэсэгтэй харилцан уялддаг. Энэ хэсэг нь Мосе Мидианчуудын гэр бүлээ орхин явсан тухай өгүүлдэг. Энд Гершомын тухай дахин өгүүлэх ба Мосе түүнийг хозлуулаагүй тухай байдаг. Энэ хэсэгт Эхлэл 17:10-14 дээрх Абрахамтай байгуулсан гэрээгээ сахиж, Бурхан Мосег хөнөөнө хэмээн сүрдүүлдэг. Гэвч энэ үйл явдал нь хүртэл Мосегийн удирдлагыг Бурхан дэмжиж байсныг харуулсан. Учир нь Мосегийн Мидиан эхнэр Зипшора хүү Гершомоо хозлох үед Бурхан өршөөн хэлтрүүлснийг мэднэ шүү дээ.

Эцэст нь анх Мосе Египетээс зугтаж байсан бол Гэтлэл 4:27-31 дээр тэрээр Ааронтой хамт Египет рүү буцаж ирснээр түүх тэнцвэрждэг. Мосе удирдагч болсон нь ч энд мөн батлагдлаа. Бурхан Мосег илгээсэн тул Израилчууд Бурханд итгэж, Түүнийг хүндлэн мөргөснийг бид 4:31 дээрээс харж болдог.

Бидний ярьдаг түүхүүдийг, ер нь ямар ч түүхийг сонсоод үзвэл тэдгээр нь тодорхой хэв маяг бүхий хэсгүүдтэй байдаг. Тэдгээрт эхлэл, төгсгөл, өрнөл, эргэлтийн цэг болон төгсгөл байх ба иймэрхүү байдлаар тэгш хэмтэй байдаг... Тэгэхээр бид Библийн хүүрнэлд энэ мэт тэгш хэмтэй бүтэц олж хараад гайхах шаардлага байхгүй. Чухамдаа иймэрхүү зүйлийг л бид Библийн хүүрнэлээс хүлээж найдах байсан биз. Библийн түүх өгүүлэгчид, Библийн хүүрнэгчид эдгээрийг санаанаасаа огт зохиогоогүй. Тэд үүнийг уран яруу болгох гэж мушгин гуйвуулж, ийм хэлбэрт оруулаагүй юм. Харин аливаа түүх ямар хэлбэртэй байдаг тэр арга хэлбэрээр л бидэнд бичиж үлдээсэн нь энэ юм шүү дээ. Ийнхүү бичигдсэнийг ойлгож, тухайн хүүрнэл хэрхэн ажиллаж буйг мэдэх нь бид чухам юуг анхааран харж, ойлгож мэдэх ёстойг чиглүүлж өгдөг юм аа.

- Др. Гордон Х. Жонстон

Бид Израилыг чөлөөлөхөөс *өмнөх* үеийн түүхийг харсан тул одоо Гэтлэл 5:1–18:27 дээрх Израилын чөлөөлөлтийн *үеийн* Мосегийн үйл хэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй.

Чөлөөлөлтийн Үе (5:1–18:27)

Израилын чөлөөлөлтийн үеийн Мосегийн үйл хэрэг нь түүний Египетэд байх үеэс эхэлдэг бөгөөд Гэтлэл 5:1–13:16-д өгүүлдэг. Үүний дараа Мосегийн удирдлагын талаар бид ард түмнийг Египетээс Синаи Уул өөд дагуулан явснаас нь харж болдог. Энэ тухай Гэтлэл 13:17–18:27 дээр бий. Эхлээд Египетэд байсан Мосегийн амьдралыг харцгаая.

Египетэд (5:1–13:16). Мосегийн Египетэд байсан цаг хугацаа нь түүний эсрэг гарсан зарим эсэргүүцэлд хариулт өгдөг. Учир нь түүний хийсэн анхны чөлөөлөх оролдлого нь санамсаргүйгээр Израилчуудыг улам зовооход хүргэсэн байдаг.

5:1–6:27 дээр Израил Мосегийн удирдлагаас татгалзсан явдал, Мосегийн гашуудал болон Бурханы тайвшруулал зэргийг багтаасан хоёр зэрэгцээ хэсгүүдийг бид уншдаг. Эхний хэсэг 5:1–6:8-д харагдана. Фараоныг өөрсдийнх нь эсрэг болголоо гэж Израилчууд Мосег эсэргүүцэв. Мосе даруугаар гашуудсан. Тэгээд Бурхан Израилыг удирдах дуудлагынхаа тухайд Мосег тайвшруулав.

6:9–27 дээрх хоёр дахь хэсэг нь ижил төстэй хэв маягийг харуулна. Гэвч Израил Мосегоос хоёр дахь удаагаа татгалзаж, тэрээр хоёр дахиа гашуудсаны дараа Бурханы тайвшруулал нь угийн бичиг хэлбэрээр ирдэг. 6:13–27 дээр Мосе, Аарон хоёрын өвөг дээдэс Левигээс эхлүүлээд Аароны ач хүү Финехас хүртэлх удмыг харуулдаг. Мэдээж Леви бол Израилын арван хоёр овгийн нэг байсан. Тооллого 25 ба 31-р бүлэгт өгүүлснээр Финехас хоёр дахь үеийн Израилчуудыг Бурханд үнэнч үйлчлэхэд удирдан чиглүүлсэн. Энд Бурхан хоёр дахь үеийнхэнд Мосе, Аарон хоёрыг Иаковын овгуудаас гаралтай, жинхэнэ Израилчууд гэдгийг баталгаажуулан хэлсэн. Мөн ард түмэн Мосе, Аарон хоёрын үнэнч өв болох Финехасыг нүдээр харж, тэднийг чиглүүлэхээр Бурхан тэднийг дуудсан байсан гэдэгт нь итгэлтэй болсон.

Энэ нь Египет дэх Мосегийн үйл хэргийн хоёр дахь гол хэсэгт биднийг чиглүүлдэг. Энд Гэтлэл 6:28–13:16-д Египетийн дээр буулгасан Бурханы гай гамшиг бүхий шүүлтийн тухай өгүүлнэ. Эдгээр бүлгүүд нь Египетчүүдийн эсрэг хийсэн Бурханы ер бусын шүүлтийн үйл ажиллагаанд Мосегийн гүйцэтгэсэн чухал үүргийг онцлон, түүний эрх мэдлийг баталсан байдаг.

Хамгийн эхний шүүлт болох могойн талаар 6:28–7:13-т гардаг. Аароны таяг гайхамшигтай байдлаар могой болон хувирч, Фараоны илбэчдийн бий болгосон могойнуудыг залгиснаар Египетийн эсрэг Бурханы хүчийг харуулдаг. Энэхүү эхний гайхамшигийн дараа Гэтлэл 7:14–10:29 багц эшлэлд цуврал есөн шүүлт гардаг. Эдгээр есөн шүүлт нь гурван хэсэгт хуваагддаг бөгөөд тус бүр нь Мосе Нил мөрний дэргэд Фараонтой тулгарснаар эхэлдэг.

Эхний цуврал гамшгууд нь 7:14–8:19 хооронд үргэлжилнэ. Үүнд усыг цус болгож, газрыг мэлхийгээр дүүргэж, тоос шорооноос дэлэнч бий болгосон гайхамшгууд багтана. Хоёр дахь цуврал гамшгууд нь 8:20–9:12 хооронд гарах ба бөөн ялаа, малын тахал, буглаат хатги зэрэг багтана. Гурав дахь цуврал гамшгууд нь 9:13-10:29 хооронд үргэлжилнэ. Үүнд аянга мөндөр, царцаа, түнэр харанхуйн шүүлтүүд орно. Эдгээр бүх гайхамшиг бүхий шүүлтүүдэд Мосе чухал үүрэг гүйцэтгэсэн нь түүний Израилын удирдагчийн эрх мэдлийг батлан харуулдаг. Эцэст нь 11:1–13:16 дээрх Алгаслын шүүлтээр энэ хэсэг өндөрлөдөг. Бурхан Египетийн ууган хүү бүрийг алсны дараа Фараон эцэстээ нэг Израилыг явуулав.

Израилыг чөлөөлөх үед Египетэд болсон үйл явдлуудыг харлаа. Одоо бид Египетээс Синаи Уул руу явах аянд Бурхан Мосегийн эрх мэдлийг хэрхэн баталж байсан талаар Гэтлэл 13:17–18:27 дээрээс харцгаая.

Аян замд (13:17–18:27). Синаи руу хийсэн аяллын үеэр Израилд тулгарч байсан бэрхшээлийг үл харгалзан Израил Египетээс бэлтгэлгүйгээр гараагүй гэдгийг тэмдэглэх нь чухал юм. Гэтлэл 13:18-д Израилын хөвгүүд Египет нутгаас “байлдааны бэлтгэлтэй” гарсан тухай тодорхой өгүүлдэг. Энэхүү цэргийн сэдвийн хүрээнд авч үзвэл энэ хэсэг бүхэлдээ бусад үндэстнүүдтэй зөрчилдөх тухай, мөн Израилын армид ус, хоол хүнс хэрэгцээтэй байхыг харуулах аж.

Израилын байлдааны цуваагаар явах аян нь үндсэн дөрвөн хэсэгт хуваагддаг. Эхний хэсэг буюу 13:17–15:21 дээр улаан тэнгист Мосегийн эрх мэдлийг нотолсон тухай өгүүлдэг. Гэтлэл 14:31-д Израилчууд улаан тэнгисийг хуурай газраар гаталсны дараа бид Мосегийн эрх мэдлийг хэрхэн баталсан талаар олж уншдаг. Энд:

“Ард түмэн ЭЗЭНээс эмээн ЭЗЭН хийгээд Түүний зарц Мосед итгэв” гэжээ (Гэтлэл нь 14:31).

Энэ эшлэл нь энэ хэсгийн гол санаануудыг хурцаар дүрсэлж байна. Израилын арми "Бурхан ЭЗЭНээс эмээн ЭЗЭНд итгэв". Мөн тэд "Түүний зарц Мосед" бас итгэжээ. Мэдээжийн хэрэг эдгээр үгс Гэтлэлийн анхны сонсогчдод ойлгомжтой байв. Тэд ч мөн адил өөрсдийн үед Бурхан болон Мосед итгэх ёстой ажээ.

Үүний дараа Израилын арми 15:22-27 дээр Шурын цөл рүү явлаа. Шурын цөлд хүмүүс Мосегийн олсон ус нь уух аргагүй байсанд түүний эсрэг гомдоллож, түүний эрх мэдлийг сорив. Тиймээс Бурхан Мосед усыг цэвэршүүлэх модыг өгснөөрөө түүнийг Израилын удирдагчаар өргөмжилснөө харуулав.

Гурав дахь хэсэг буюу 16:1-36-д Израилчууд Син цөлд хүрч ирсэн тухай бий. Син цөлд Израилчууд Мосе, Аарон хоёрт гомдоллож, Мосегийн удирдлагыг дахин эсэргүүцэв. Гэвч энэ удаад 7-р эшлэлд Мосе тэд үнэхээр *Бурханы* эсрэг гонгинон гомдоллож байна хэмээн батлан өгүүлсэн байдаг. Харин Бурхан Израилд хоол хүнс болгон бөднө шувууг өгч, тэдэнд тогтмол манна өгснөөр Мосегийн эрх мэдлийг дахин нотлов.

Бурхан цөлд Мосегоор дамжуулан хүмүүсийн хэрэгцээг хангаж байснаараа түүний эрх мэдлийг баталсаар байдаг. Хэдийгээр тэд Мосегийн эсрэг болон Эзэний эсрэг гомдоллодог ч Бурхан нигүүлслээрээ хаднаас ус гарган, тэнгэрээс маннаг буулган

тэднийг хангадаг. Энэ бүхэн нь зөвхөн эцгийн халамж төдий бус, Мосе бол үнэхээр Түүний илгээсэн нэгэн мөн гэдгийг батлахын тулд юм... Христитгэлтнүүд бид ихэнхдээ хүнд итгэх хэрэггүй, ямар нэг хүнд найдах хэрэггүй гэж боддог. Гэхдээ энд хүмүүсийг зөвхөн Эзэнд итгэл найдвараа тавихыг уриалаад зогсохгүй Эзэний хэрэгсэл, төлөөлөгч болох Мосед ч тавихыг онцгойлон сануулж байна. Бид үүнийг Улаан тэнгисийг гатлахад араас нь нэхэж явсан Египетийн цэргийг живүүлсэн гайхамшигт ялалтын үед ч харсан. Тэнд тэд тэнгисийн нөгөө эрэгт гараад баярлалдан, Бурханыг магтан дуулж, Бурханд болон Мосед итгэсэн тухай өгүүлдэг.

- Проф. Томас Еггер

Гэтлэл 17:1–18:27 дээр Израилын аялсан дөрөв дэх бөгөөд сүүлчийн газар бол Рефидим байв. Энэхүү харьцангуй урт хэсэг нь гурав хуваагддаг. Нэгдүгээрт, Гэтлэл 17:1-7 дээр хүмүүс усны талаар дахин гомдоллохдоо Бурханыг сорьсон байдаг. Үүний хариуд Бурхан Мосед ахлагчдыг Синаи Уулан дээр авчрахыг тушаажээ. Тэнд Бурхан Мосед хадыг цохихыг тушааснаар ус гарч ирэв. Гэсэн хэдий ч энэ гайхамшигийг үл харгалзан Израилчууд Бурхантай улам бүр маргалдав. Тэд 7-р эшлэлд эсэргүүцэн гайхширч, "ЭЗЭН бидний дунд байна уу, үгүй юү?" гэжээ. Дараагийн хоёр хэсэг энэ асуудлыг намжаадаг.

Одоо эдгээр үйл явдлууд өмнөх асуултад хэрхэн хариулж байгааг ойлгохын тулд Израилчуудын сайн мэддэг зүйлийг бид санах хэрэгтэй. Эхлэл 12:3-т Бурхан Израилыг ерөөгчдийг Би ерөөж, тэднийг хараагчийг Би хараана гэж Абрахамд амласан байдаг. Тиймээс энэхүү амлалттай адилаар Гэтлэл нь 17:8-16 дээр Амалекчууд Израил руу дайрах үед Бурхан тэднийг ялж, тэднийг хараасан юм.

Дараа нь энэ хэсгийн сүүлчийн хэсэгт буюу 18:1-27-д Иетро Мосе дээр амар тайвныг тогтоохоор ирэв. Иетро Израилчуудыг ерөөсөн тул Бурхан Иетрог ерөөв. Энэ хоёр үйл явдал нь Бурхан Абрахамд яг л амласан ёсоороо Израилчуудын дунд байсныг ямар ч эргэлзээгүйгээр харуулсан. Израилын арми Мосег дагаж байхдаа Бурханы хүчирхэг оршихуйн хамгаалалтыг хүлээн авсан.

Одоог хүртэл бид Гэтлэлийн бүтэц, агуулга нь эхлээд Израилыг Египетээс чөлөөлөн Синаи Ууланд хүргэх явдал байсныг, мөн Мосед анхаарал хандуулснаар түүний эрх мэдлийг тодотгож байгааг харлаа. Одоо бид Гэтлэл 19:1–40:38 дээрх номын хоёрдугаар хагасыг авч үзэцгээе. Эдгээр бүлгүүд нь Мосе болон Синаи Ууланд Канаан руу ороход тэднийг бэлтгэж байсан тухай өгүүлэх замаар Мосегийн эрх мэдлийг харуулдаг.

КАНААН РУУ БЭЛТГЭЛ (ГЭТЛЭЛ 19:1–40:38)

Израилчууд Синаи Уулын бэлд буудаллах үед тэдэнд болон Мосед юу тохиолдсоныг, Бурхан тэдэнд хууль болоод асраа хэрхэн өгснийг Библийн ихэнх оюутнууд мэддэг. Гэвч тэнд бодитоор тохиолдсон цөөн хэдэн зүйлсийг л Гэтлэл бидэнд хэлж өгдөг. Учир нь Левит номд тухайн үед тохиолдсон өөр бусад зүйлсийг бидэнд өгүүлдэг шүү дээ. Тиймээс эдгээр бүлгүүдэд хамгийн чухал зүйлсийг сонгож

бичсэн гэдгийг харж болно. Тэд эдгээр үйл явдлын талаарх тодорхой өнцгийг онцлон харуулахыг зорьсон гэсэн үг. Бидний харж байгаачлан эдгээр нь онцгойлон Синаи Ууланд байхад нь Израилыг захирах Мосегийн эрх мэдлийг Бурхан хэрхэн харуулж буйд анхаардаг.

Мосе ба Израилчуудын Канаан руу орох бэлтгэлийг хоёр үндсэн хэсэгт хуваадаг. Эхний хэсэг нь Гэтлэл 19:1–24:11-д гардаг бөгөөд Мосегийн эрх мэдэл болон Израилын гэрээний тухай өгүүлдэг. Мөн 24:12–40:38 дээрх хоёр дахь хэсэг нь Мосегийн эрх мэдэл болон Израилын асрын тухай онцолсон байдаг. Эхлээд Израилын гэрээг харцгаая.

Израилын гэрээ (19:1–24:11)

Одоо, Израилын гэрээний талаарх энэхүү хэсэг нь Гэтлэлийн анхны хүлээн авагчдын хувьд нэн чухал дараах асуултад хариулдаг. Гэтлэлийн хоёр дахь үеийнхэн яагаад Синаи Уулан дэр Мосегээс өвөг дээдсийнхээ хүлээн авсан гэрээний хуульд захирагдах ёстой вэ? Тэд яагаад өөр замаар явж болохгүй гэж?

Израилын гэрээний талаарх уг бүлгүүд энэ асуултад дөрвөн үе шаттайгаар хариулдаг. Нэгдүгээрт, Гэтлэл 19:1-ээс эхлэн 8-р эшлэл хүртэл бид Израилын Бурхантай байгуулсан гэрээний үндсийг олж хардаг.

Гэрээний үндэс (19:1-8а). Эдгээр багц эшлэлд Мосегийн гэрээний үндсэн нөхцөлүүдийг гарган харуулдаг. Эдгээр нь Бурхан Израилчуудад өршөөл энэрлээ үзүүлсэн, Тэр тэднээс үнэнч байхыг шаардсан бөгөөд хэрэв тэд Түүнд дуулгавартай байвал ерөөгдөх болно гэсэн нь юм. Гэтлэл 19:8-д "ЭЗЭНий айлдсан бүхнийг бид биелүүлнэ" гэсэн Израилын урам зоригтой бөгөөд санал нэгтэй хариултаар энэ хэсэг төгсдөг. Мэдээжийн хэрэг, Гэтлэлийн хоёр дахь үеийн хүлээн авагчид өөрсдийн өвөг дээдсээ дуурайх ёстой гэдэг санаа маш тодорхой байна. Тэд адилхан урам зоригтойгоор Мосегоор ирсэн Бурханы гэрээнд өөрсдийгөө зориулах ёстой аж.

Израилын Мосед итгэх итгэл (19:8б–20:20). Мосегийн эрх мэдэл ба Израилын гэрээний хоёр дахь алхам нь Бурханы гэрээний зуучлагчийн хувьд Израилын Мосед итгэх итгэл дээр төвлөрдөг. Энэ нь Гэтлэл 19 бүлгийн 8-р эшлэлийн хоёрдугаар хагасаар эхэлж, 20:20 хүртэл үргэлжилдэг. Гэтлэл 19:9 эшлэлд Бурхан Мосед дараах амлалтыг өгсөн байдаг. Энд:

“Үзэгтүн, чамтай Миний ярихыг ард түмэнд сонсож, тэднийг чамд үүрд итгүүлэхийн тулд Би чам руу өтгөн үүлээр очно гэв” гэжээ (Гэтлэл 19:9).

Бурхан Синаи Ууланд ирж, Мосетэй ярилцахад “ард түмэн... [Мосед] үргэлж найдах болно” гэж хэлснийг энд анзаараарай. Тэгээд Бурхан энэ амлалтаа хэрхэн биелүүлснийг дараагийн хэсгүүдэд тайлбарладаг.

Энэ алхмын гол хэсэг нь Бурханы теофани буюу Өөрийгөө харуулсан болон Мосегийн дуулгавартай байдал гэсэн хоёр зэрэгцсэн заавраас бүрддэг. Эхний цуврал

нь 19:10-19-р эшлэлд гардаг бөгөөд Бурхан Мосед Израилыг Бурхантай уулзуулахад бэлтгэхийг зааварласан байдаг. Мосе Бурханы зааврыг дуулгавартай дагасан ба үр дүнд нь Синаи Уулан дээр Бурханы оршихуйн сүр жавхлант, харагдахуйц, сонсогдохуйц илрэл бүхий гайхалтай теофани бий болов.

Дараа нь бид Гэтлэл 19:20-25-р эшлэлээс хоёр дахь цувралыг уншина. Хүмүүсийг бэлтгэхийг Бурхан Мосед дахин зааварласан бөгөөд Мосе дуулгавартай дагасан. Үүний үр дүнд буюу 20:1-17 эшлэлд Синаи Ууланд Бурхан бүх Израилд сонсогдож, Арван Хуулийг айлдсан теофани бүхий хүүрнэл бий.

Энэ хэсгийн эхлэл хэсэг дэх Бурханы амлалтын хэсгийг тэнцвэржүүлж Гэтлэл 20:18-20 дээр Мосед өгсөн Бурханы амлалт биелсэн гэдгийг тайлбарлаж байна. Уулнаас Бурханы дуу хоолойг сонссон Израилчууд маш их айж, өөрсөдтэй нь шууд ярихаа болиоч гэж Бурханаас гуйсныг эдгээр эшлэлүүд дүрсэлдэг. Бурханы өмнөөс тэдэнтэй ярилцахыг Израилчууд Мосегоос гуйв. Хоёр дахь үеийн хүлээн авагчдын хувьд энэ хүсэлтийн утга нь маш тодорхой харагдана. Тэдний өвөг дээдэс Мосег Бурханы гэрээний хуулийн зуучлагчаар байлгах хүсэлтэй байсан бөгөөд тэд ч мөн адил тэгж хандах ёстой.

Мосегийн Гэрээний Хууль (20:21–23:33). Мосегийн эрх мэдэл ба Израилын гэрээний тухай энэ хэсгийн гурав дахь алхмыг Гэтлэл 20:21–23:33 дээрээс олж болно. Эдгээр бүлгүүд Мосегийн гэрээний хуулийн агуулгыг танилцуулдаг. Энэ хэсэг бүхэлдээ Израилд хуулийг хүргэх ажлыг Бурхан Өөрөө Мосед тушаасан гэдгийг тэмдэглэснээр түүний эрх мэдлийг баталж байна.

Энэ алхмыг 20:21-26 дээр танилцуулсан. Энд Бурхан Мосед мөргөлийн талаарх хуулиа буюу шүтээнүүд болон тахилын ширээний тухай зааварчилгааг Израилд хэлэхийг зааварлажээ. Эдгээр эшлэлүүд Арван Хуулийн эхний хоёрыг голчлон тайлбарласан байдаг. Үүний дараа 21:1–23:33 дээрх Гэрээний Номын агуулгыг Израилд хэлэхийг Бурхан Мосед зааварласан.

Гэрээний Ном Израилд ямар үүрэг гүйцэтгэх ёстойг ойлгохын тулд Гэтлэл 21:1 эшлэлд Бурхан Гэрээний Номыг дараах байдлаар дүрсэлсэн болохыг анхаарах нь чухал. Энд:

“Чиний тэдэнд өгөх шийдвэрүүд энэ юм” гэжээ (Гэтлэл нь 21:1).

Энд "шийдвэрүүд" гэж орчуулсан еврей хэллэг нь *חַמְּטִינָתִי* (*хаммишпатим*) юм. Энэ нэр томъёо нь "хууль ёсны шүүлтүүд" буюу биднийхээр "жишиг хуулиуд" гэсэн утгатай. Гэрээний Номын энэхүү тодорхойлолт нь Мосегоор дамжуулан өгсөн Бурханы хоёр талт гэрээний талаар тодорхой чиг баримжаа өгдөг. Үндсэндээ Арван Хууль нь бичигдмэл хууль буюу Израилын хууль эрх зүйн ерөнхий зарчмуудын үүрэг гүйцэтгэдэг байв. Харин Гэрээний Ном нь Израилын шүүгчдийн олон янзын сэдвээр дагаж мөрдөх ёстой хууль эрх зүйн жишгүүдийг харуулсан. Эдгээрийн олонх нь *Хаммурабигийн хууль* болон бусад эртний Ойрх Дорнодын хуулийн кодуудтай төстэй байдаг. Энэхүү кодууд болон Гэрээний ном нь шүүгчид өөрсдийн улс үндэстний шүүхэд хэрэглэхэд зориулагдсан болно.

Гэрээний ном нь эртний Ойрх Дорнодод МЭӨ III мянганы сүүлээс МЭӨ II мянганы хооронд байсан хууль эрх зүйн кодуудтай олон талаараа ижилссэн байдалтай харагддаг. Энэ нь гэрээний нөхцөлөөрөө ялгаатай. Хаммурабигийн код бол эдгээрээс хамгийн алдартай, хамгийн өргөн цар хүрээтэй нь юм... Хуулиуд нь "Хэрэв-тэгвэл-тэгнэ" гэсэн загвараар томъёологдсон байдаг. Энд буй "тэгнэ" гэдэг нь тухайн нөхцөл байдалд ихэвчлэн иргэнд хориг зааг тавихад ашиглагддаг. Энэ нь Гэтлэл номын 21:1-22:16 хүртэлх дээр буй хуулиудыг хэрхэн томъёолсонтой тун төстэй. Миний бодлоор энэ нь "хэрэв-тэгвэл" гэсэн нэг төрлийн бүтэцтэй байна. Үүнийг кэйс хууль буюу тухайн нөхцөлийг харгалзан шүүхийн шийдвэрээр тогтоосон хууль гэж нэрлэдэг. Илүү нарийн харвал эртний Израилын нийгэм болон Месопотами дахь хот-улс болох эртний Вавилоны нийгэм хоёрын хооронд ялгаа их бий. Вавилонтой адил хот-улс нь нийгмийн давхраажилт ихтэй байдаг. Чөлөөт хүмүүс, анхнаасаа эрх чөлөөтэй төрсөн хүмүүс ба энгийн иргэд нь нэг өөр түвшинд, дараа нь боолууд нэг өөр түвшинд байна. Бас нийгэмд эдийн засгийн хувьд гүйцэтгэх үүргээрээ ялгаа бүхий эдийн засагтай. Бүхэл бүтэн эдийн засагт нөлөөлдөг хүчирхэг сүмийн цогцолбортой. Ордон, хааны ордон бол нийгмийн бүтцэдээ голлох хүчин зүйл болдог. Энэ нь бидний төсөөлдөг дундад зууны үеийн феодалын нийгэм шиг, за бараг л феодалын нийгэм байсан гэхэд болно. Израилын нийгэм нь илүү тэгш эрхт нийгэм байсан. Гэвч энэ нь орчин үеийн хувь хүн төвт нийгэмтэй адилгүй байв. Харин газар тариаланд суурилсан эдийн засагтай, газар эзэмших овгийн зохион байгуулалттай байжээ. Тэгэхээр Израил нь Хаммурабигийн кодоос онцлогоороо ч, нийгмийн давхаргаараа ч ялгаатай байсан гэж хэлж болно.

- Др. Дуглас Гропп

Гэрээг Баталгаажуулах нь (24:1-11). Гэтлэл 24:1-11-д Мосегийн эрх мэдэл ба Израилын гэрээний төгсгөлийн дөрөв дэх үе шатанд гэрээг баталсан тухай тэмдэглэсэн байдаг. Энэхүү дөрөв дэх алхам нь Гэтлэл 19:1 дээрх гэрээний эхлэлээс 8-р эшлэлийн эхний хэсэг хүртэл үргэлжилдэг. Гэтлэл 24:3 ба 7-р эшлэлүүд хоёулаа 19:8-р эшлэлийг цуурайтуулж, Бурханы тушаасан бүхнийг хийх амлалтаа Израил нэгэн дуугаар давтсан гэдгийг онцгойлон анхаараарай.

Үүнээс гадна энэ үе шатын сүүлчийн дүрслэл нь Израилын удирдагчид Синаи Уулан дээр гарч, Бурханыг үзэцгээж, идэж ууцгаасныг дүрсэлдэг. Бурхантай энх тайван, эв найртай байх энэхүү үзэгдлийн гайхамшиг нь Гэтлэлийн анхны хүлээн авагчдын аливаа эргэлзээг арилгах зорилготой байв. Тэд хэрхэн Бурхантай энх тайван, эв найртай байх вэ? Зөвхөн өөрсдийнхөө үед Мосегоор ирсэн Бурханы гэрээний хуулийн үргэлжлэх эрх мэдлийг хүлээн зөвшөөрснөөр л юм.

Ингээд бид Гэтлэл 19:1–24:11 дээрх Израилын гэрээг харснаар Синаи Ууланд Мосе болон Израилын Канаанд орох бэлтгэлийн талаар судаллаа. Тиймээс одоо Гэтлэлийн сүүлчийн гол хэсгийн авч үзэх хэрэгтэй. Гэтлэл 24:12–40:38 дээр

Мосегийн эрх мэдэл болон Израилын асрын тухай онцолсон байдаг. Эдгээр бүлгүүд нь Мосегийн Бурханы асрыг байгуулахад гүйцэтгэсэн чухал үүрэгт анхаарлаа төвлөрүүлснээр Түүний үргэлжлэх эрх мэдлийг хөхүүлэн дэмждэг.

Израилын Асар (24:12–40:38)

Библийн ихэнх суралцагчид Израилын асрыг мөргөл үйлдэх жижиг сүмээс өөр зүйл биш гэж боддог боловч сүүлийн үеийн археологийн олдворууд нь үүнээс ч илүү утгатай байсныг баттай нотолж байна. Эртний Египетийн заншил ёсоор фараонууд армитайгаа тулалдахаар гардаг байжээ. Тэд ингэхдээ хөдөлгөөнт ордон мэт зүйл буюу нарийн хийц бүтэцтэй майханд амьдардаг байв. Эдгээр хааны дайны майхнууд нь хашаагаар хүрээлэгдсэн гадна болон дотор талын битүү тусгаарлалтуудтай байв. Эдгээр майханд цэргүүд хаандаа хүндэтгэл үзүүлж, хаанаасаа заавар хүлээн авдаг байв. Үүнтэй адилаар Гэтлэл нь Бурханы асрыг мөргөл үйлдэх жижиг сүмээс илүү сүрлэг байсан гэж танилцуулдаг. Энэ бол Түүний хаанчлалын дайны майхан байв. Ийнхүү энэхүү асар майханд Израилын арми тэнгэрлэг хаандаа хүндэтгэл үзүүлж, тэнгэрлэг хаан нь Өөрийн зааврыг армидаа илчилдэг байв.

Асрын Зааврууд (24:12–31:18). Мосегийн эрх мэдэл ба Израилын асрын тухай бичигдсэн зүйлс үндсэн гурван хэсэгт хуваагддаг. Нэгдүгээрт, Гэтлэл 24:12–31:18 нь асрын талаарх Мосед өгсөн Бурханы заавруудаас бүрддэг. Асарт зориулсан Бурханы зааврууд нь Гэтлэл 24:12-18-д Бурхан Мосег чулуун хавтан дээрх Арван Хуулийг хүлээн авахыг дуудсанаар эхэлдэг. Дараа нь асрын талаарх Бурханы тусгай зааврууд нь 25:1–31:17-д гардаг. Эдгээр нь асрын эд зүйлс, архитектурын нарийвчилсан тайлбаруудыг өгдөг. Бурхан мөн асарт үйлчлэл, зан үйлийн удирдамжийг тахилчид, гар урчууд, чадварлаг ажилчдад зааварчлав. Мөн Тэрээр долоо хоног бүрийн Амралтын өдрийн талаар шууд зааврууд өгсөн. Бүх зүйлийн тоо хэмжээ, урт өргөнийг нарийн тодорхой өгсөн нь Бурханы хаанчлалын дайны асарт тодорхой тогтоол зааврыг дагаж мөрдөхийн чухлыг харуулдаг. Эдгээр үндсэн заавруудын дараа бид Гэтлэл 31:18-с Арван Хуулийг агуулсан чулуун хавтангуудыг Мосе амжилттай хүлээн авсныг олж хардаг. Энэ нь асрын талаарх Бурханы заавруудыг дуусгавар болгосон байдаг.

Одоо, энэ хэсэгт хэд хэдэн удаа Бурхан Өөрийнх нь зааврууд зөвхөн Синаи Уулан дахь Израилчуудад зориулагдаагүй гэдгийг тодорхой заасан. Тэд мөн Гэтлэлийн хоёр дахь үеийн хүлээн авагчдад зориулагдсан байв. Гэтлэл 27:21, 28:43, 29:9 ба 42, 30:21 мөн 31:16-д Бурхан “*хамаг үеийнхний сахих үүрдийн зарлиг*” гэсэн хэллэгийг хэд хэдэн байдлаар өгүүлдэг. Энэ нь асрын талаарх Түүний заавруудыг хойч үеийнхэн хэрхэн дагаж мөрдөхийг харуулсан. Мэдээжийн хэрэг, анхны хүлээн авагчдад зориулан ийнхүү тэмдэглэн үлдээсний зорилго нь тодорхой байв. Тэд асрын талаарх Бурханы заавруудыг мөн өөрсдийнхөө өдрүүдэд сахих ёстой ажээ.

Гэтлэл номд зааврын дагуу асрыг хэрхэн яаж барих технологийн талаар олонтоо дурддаг. Хөндлөвч болон багана модыг хэрхэн тогтоох, дараа нь үүнийг буулган, зөөвөрлөн явахад тохиромжтой байхаар хэрхэн хийх гэх мэт. Египетэд олон зууны туршид үүнтэй

ижил зүйлс байсаар байжээ. Тэдгээрээс хамгийн их төстэй нь Кадешийн тулалдааны үед Абу Симбелийн сүмд хийсэн II Рамсесийн дурсгал байв. Тэрээр өөрийгөө ялсан гэж тунхагласан боловч ихэнх эрдэмтэд түүнийг амьд гарсан нь л аз байсан гэдэг. Гэхдээ Абу Симбелийн ханан дээрх түүний дурсгалд түүний асрыг буюу дайны асрыг нь дүрсэлсэн байдаг. Энэ нь түүний сэнтийн өрөө байсан байж мэдэх дөрвөлжин дотоод өрөө бүхий Библийн асрын хэмжээтэй яг ижил хэмжээтэй өрөө байдаг. Мөн үүдний хэсэг нь үүнээс хоёр дахин урт байх ба гадна талд нь Библийн асрын эргэн тойронд байдагтай адил тэгш өнцөгт талбай бүхий хашаатайгаар зуржээ. Түүнчлэн Тооллого номд дурдсантай адил цэргийн дөрвөн дивиз нь хуарангийнх нь дөрвөн талд байрлаж байгааг бид түүний дурсгалаас харж болно. Асрыг эхлээд левичүүд, дараа нь дөрвөн зүгт гурван овгийн дөрвөн хуаран хүрээлсэн байдаг.

- Др. Дуглас Гропп

Уналт ба Сэргэлт (32:1-34:35). Асарт зориулсан Бурханы заавруудын дараа Гэтлэл 32:1–34:35-д Мосе Синаи Уулын бэлд тохиолдсон Израилын уналт хийгээд сэргэлтийн тухай өгүүлсэн. Эдгээр бүлгүүд нь гурван гол үе шатад хуваагдана. 32:1-35-д Израилчууд Синаи Ууланд алтан тугалд мөргөж, Бурхантай байгуулсан гэрээгээ зөрчсөн тухай бид уншдаг. Эдгээр бүлгүүд нь Мосегийн эрх мэдлийг зөвтгөдөг. Яагаад гэвэл Мосе өөрийгөө Израилтай адилтгаж, тэдний төлөө зуучлан залбирсан. Мосе амь насаа эрсдэлд оруулж, зуучилж, Израилд хандсан Бурханы тааллыг олж авсан юм. Мөн Бурхан уг үндэстнийг бүрмөсөн устгахаа болив.

Дараа нь Гэтлэл 33:1-23-д уг хэсгийн хоёр дахь үе шатад Бурхан тэдэнтэй хамт байхгүй хэмээн сүрдүүлсэн байдаг. Үндэстнийг нэн даруй устгахгүй байхаар тохиролцсоны дараа Бурхан Мосед урагшлахыг тушаажээ. Гэвч Бурхан Израилыг замд нь устгаж магадгүй учраас Өөрийн оршихуйгаа тэднээс авна хэмээн сүрдүүлэв. Гэвч Мосе дахин нэг удаа өөрийгөө уг үндэстэнтэй адилтгаж, Израилын өмнөөс зуучлан гуйж, Бурхан хамт байхгүй байх аюулаас гэтэлгэв.

Гуравдугаар шат нь 34:1-35-д гарах ба энд Израилтай хийсэн гэрээгээ Бурхан шинэчилсэн байдаг. Бурхан Өөрийн гэрээгээ шинэчилснээр Израилтай хамт Канаан руу явна гэдгээ баталгаажуулав. Мөн энэ бүлэгт гэрээг шинэчлэх үед Мосегийн үйлдсэн үр дүнтэй зуучлан залбирлуудыг дурдсанаар Израилын удирдагчийн хувьд түүнийг өргөмжилсөн юм.

Асар барьж дуусгасан нь (35:1–40:38). Эцэст нь Гэтлэл 35:1–40:38-д Мосегийн эрх мэдэл ба Израилын асрын тухай хэсэг нь асрын ажил дууссанаар төгсдөг. Эдгээр бүлгүүд 35:1-3-т долоо хоног бүрийн Амралтын өдрийг сануулснаар эхэлдэг. Дараа нь 35:4–39:43-т асрыг барьж, босгох даалгаврыг Бурхан Мосед өгсөн тухай байдаг. Гэтлэл 40:1-33 дээр асар сүндэрлэн баригдаж буйг дүрсэлдэг. Эдгээр эшлэлүүдэд дурдсан бүхэн нь Бурханы хаанчлалын дайны майхан болох асар баригдсан нь Түүний өмнө өгсөн заавруудтай хэрхэн төгс нийцэж байгааг харуулдаг. Мөн энэ хэсэг 40:34-38-д Бурхан асрыг дуусгасны хариуд Израилыг ерөөснөөр

төгсдөг.

Израилыг Бурхан ерөөж буй энэхүү эцсийн дүр зураг нь Мосегийн эрх мэдэлд дахин анхаарлаа хандуулдаг. Энэ нь анхны хүлээн авагчдыг Бурханы асрын бүх дүрэм журмыг дагаснаар Мосед захирагдахыг урамшуулсан бөгөөд ингэснээр тэд ч бас Бурханы ерөөлийг хүртэх болно гэдэг. Гэтлэл 40:36-38 буюу энэ номын сүүлчийн эшлэлүүдийг сонсоцгооё. Энд:

“Асрын дээрээс үүл өргөгдөх бүрд Израилын хөвгүүд аян замдаа хөдлөн, харин үүл дээш өргөгдөхгүй бол дээш өргөгдөх өдрийг нь хүртэл тэд хөдөлдөггүй байлаа. Учир нь бүх аян замынх нь туршид Израилын бүх гэрийн нүдэн дээр ЭЗЭНий үүл өдөр нь асрын дээр байж, шөнө нь түүн дээр гал үзэгддэг байв” гэжээ (Гэтлэл 40:36-38).

Мосе номоо Израилын Канаан руу хийж буй аяллынх нь талаарх сүр жавхлант хураангуйгаар төгсгөжээ. Эхний үеийнхэн асрын талаарх Мосегийн заавруудыг дуулгавартай дагасан учраас Бурханы оршихуй үлдсэн гэдгийг тэрээр онцолсон. Хоёр дахь үеийн хүлээн авагчид Бурханы гайхамшигт оршихуйг өөрсдийн нүдээр харж чадсан. Хэрэв тэд Амласан газар нутгийг байлдан дагуулах гэж нүүж байхдаа Бурханы оршихуйг өөрсөдтэйгөө хамт байлгахыг хүсэж байгаа бол Мосегийн асрын зааврууд буюу тэнгэрлэг хааныхаа хаанчлалын дайны майхны заавруудыг дагаж мөрдөх ёстой.

Тэгэхээр бид Гэтлэлийн бүтэц, агуулга, мэдэх шаардлагатай зарим зүйлсийг үзсэн учир номын гурав дахь чухал хэсэг буюу номын гол сэдвүүд рүү шилжих ёстой. Анхны хүлээн авагчдын амьдралд нөлөөлсөн Гэтлэлийн хамгийн чухал асуудлууд юу байж болох вэ? Тэдгээр гол сэдвүүд нь өнөөдөр Христийн дагалдагчдад хэрхэн хэрэгжих ёстой вэ?

ГОЛ СЭДВҮҮД

Энэ хичээлийн туршид бид Гэтлэл ном нь Мосегийн Израилыг захирах эрх мэдлийг онцлон харуулах зорилготойг онцолсон. Энэ сэдэв хэдийгээр чухал боловч номын *цорын ганц* сэдэв биш гэдгийг бид үргэлж санаж байх ёстой. Эдгээр Бичвэрүүд нь Мосегийн эрх мэдлийн үндэслэлийг бий болгохын зэрэгцээ энэхүү чухал, нэгдмэл сэдэвтэй холбоотой бусад хэд хэдэн асуудалд анхаарлаа хандуулж байдаг.

Гэтлэл нь үнэндээ Мосегийн эрх мэдлээс гадна маш олон янзын сэдвийг хөндсөн байдаг тул бид үүнийг олон янзаар дүгнэж болно. Гэхдээ номын гол сэдвүүдийг нэгтгэн дүгнэхэд хамгийн тустай стратегиудын нэг бол энэ ном нь Бурханы хаанчлалыг хэрхэн онцолж байгааг судлах явдал юм. Гэтэл энэ бол Библийг бүхэлд нь хамарсан сэдэв бөгөөд Шинэ Гэрээнд бүр оргилдоо хүрдэг тул уг номд чухалчлан авч үзэх нь бидний хувьд их чухал. Өнөө үеийн

Христитгэгчид заримдаа Гэтлэлийн энэ талыг орхигдуулах гээд байдаг. Гэвч Гэтлэлд Бурхан Израилыг Синаи Ууланд *бона фиде* үндэстэн болгон байгуулж, тэднийг Амласан Газарт, тэр байтугай дараа нь бүхий л дэлхийг Өөрийн хаанчлал болгоход бэлтгэсэн цаг үеийн тухай өгүүлдэг. Тиймээс бид уг номд Бурханы хаанчлалыг онцолсныг харж болно. Харин үүнийг харах хамгийн сайн аргуудын нэг бол Гэтлэл нь Бурханыг хэрхэн тодорхойлдог болохыг харах явдал юм. Бурхан бол Гэтлэл номын гол дүр бөгөөд энэ нь Бурханы талаар хэлэх зүйл ихтэй гэсэн үг. Хэдий тийм ч энэ нь Бурхан бол Израилын хаан гэдгийг юуны түрүүнд онцолсон байдаг.

- Др. Ричард Л.Пратт, Жр.

Гэтлэл нь Бурханыг хаан хэмээн *тодорхой* бичсэн Бичвэрийн анхны ном. Гэтлэл 15:1-18-д Израилчууд Улаан тэнгисийг хуурай газраар гаталсны дараа Мосе болон Израилчууд Эзэнд дуу дуулжээ. Дууны гол хэсэгт Израилчуудын эхний болон хоёр дахь үеийнхний амсаж туулсан зүйлсийг өгүүлдэг. Энэ нь өнгөрсөнд Бурхан Израилыг Египетээс чөлөөлсөн тухай, мөн Канааныг эзэлж, суурьших ирээдүйнх нь сайн сайханд анхаарлаа хандуулдаг. Сонирхолтой нь, Мосегийн тэнгис дэх сүүлчийн үгс нь Бурханы хаанчлал дор тэд өнгөрсөнд Египетээс чөлөөлөгдсөн бол, мөн ирээдүйд ч Канааныг эзэлж, суурьших болно хэмээн өгүүлдэг. Гэтлэл 15:18-д Мосе Бурханыг магтан хүндэлсэн тухай бий. Энд:

“ЭЗЭН үүрд мөнх хаанчилна” гэжээ (Гэтлэл 15:18).

Энэ эшлэлд хоёр үеийнхний төлөө Өөрийн хүчирхэг үйлсээ үйлдсэн Израилын тэнгэрлэг хаан «үүрд мөнх хаанчилна» хэмээн сүр жавхлантайгаар дүрсэлжээ.

Үүний гэрэлд бид Мосегийн үед Бурханы хаанчлалыг онцолсон дөрвөн арга замыг харснаар Гэтлэлийн гол сэдвүүдийг зохион байгуулах нь их тустай байх болно. Нэгдүгээрт, бид Гэтлэл 1:1–4:31-д буй Израилын хааны *гэрээг сахигч* Бурханыг судлах болно. Хоёрдугаарт, Гэтлэл 5:1–18:27 дээр Израилын *ялагч дайчин хаан* болох Бурханд Гэтлэл хэрхэн онцгой анхаарал хандуулж байгааг бид харах болно. Дараа нь бид Гэтлэл 19:1–24:11 дээрх хааны гэрээний *хууль өгөгч* Бурханы тухай сэдвийг авч үзэх болно. Эцэст нь, бид Гэтлэл 24:12–40:38 дээрх Израилын *одоогийн дайчин* болох Бурханы тухай сэдвийг авч үзэх болно. Хааны гэрээг сахигч Бурханаас эхлүүлээд эдгээр сэдэв бүрийг нэг бүрчлэн авч үзье.

ГЭРЭЭ САХИГЧ БУРХАН (1:1–4:31)

Хэдийгээр Израилын хааны гэрээг сахигч Бурханы тухай сэдэв нь Гэтлэл ном даяар гардаг боловч Гэтлэл 1:1–4:31-т голчлон онцолсон байдаг. Эдгээр бүлгүүдэд Мосег төрөхөөс өмнөх үеэс Израилын удирдагч болох хүртэлх үйл явдлуудыг дүрсэлдэг. Гэтлэл 2:24 эшлэлийг жишээ болгон сонсоцгооё. Энд:

“Бурхан тэдний [Израилчуудын] ёлох дууг сонсоод, Абрахам, Исаак, Иаковтай байгуулсан гэрээгээ санав” гэсэн байдаг (Гэтлэл нь 2:24).

Энэ нь Бурхан Өөрөөс нь эмээж байсан эх баригчдыг ерөөсөн тухай цухас дурдсанаас хойш Түүний тухай анх удаа өгүүлж буй хэсэг юм. Тиймээс энэ эшлэл их чухал. Гэтлэл эхнээсээ Бурханыг хааны гэрээг сахигч, “гэрээгээ санасан” Нэгэн гэж дүрсэлсэн.

Бичвэрт Бурхан болон гэрээнүүдийг нь дурдах болгондоо Түүнийг Израилын тэнгэрлэг хаан хэмээн тойруугаар тодотгодог. Библийн цаг үед эртний Ойрх Дорнодын агуу хаад бусад үндэстнүүдтэй гэрээ байгуулдагтай адил арга замаар Бурхан хүмүүстэй гэрээ байгуулжээ. Өнөөдөр бид эдгээр олон улсын гэрээг ихэвчлэн "эзэн хаан ба харьяат хааны хэлэлцээр" гэж нэрлэдэг. Эдгээр гэрээнүүдэд эзэн хаан нь харьяат хаан буюу тэдний үндэстэнтэй ёслол төгөлдөр гэрээ байгуулдаг байв. Израилчууд Израилын итгэмжит гэрээг сахигч Бурхан нь мөн тэдний тэнгэрлэг хаан гэдгийг ойлгосон. Мөн Тэрээр Мосегийн өдрүүдэд ажиллаж, Израилын эцэг өвгөдтэй байгуулсан гэрээгээ биелүүлсэн. Тиймээс, Мосетэй байгуулсан Бурханы гэрээ нь Израилын өвөг дээдэстэй хийсэн өмнөх гэрээтэй харшлахгүй. Харин ч энэ нь тэдгээрийн биелэл болж байсан юм. Гэтлэл 3:14-15-д Бурхан Өөрийн нэрийг Мосед хэрхэн илчилснийг харцгаая. Энд:

“БИ БОЛ БИ БАЙГАА ЮМ гэв. Тэгээд Тэр - Израилын хөвгүүдэд чи "Би байгаа намайг та нар луу илгээв... - Израилын хөвгүүдэд чи "Эцэг өвгөдийн чинь Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан ЭЗЭН намайг та нар уруу илгээв” гэжээ (Гэтлэл 3:14-15).

Энд Бурхан Мосед Өөрийг нь Египет дэх Израилчуудад “БИ БОЛ БИ БАЙГАА ЮМ”, “БИ БАЙГАА” мөн “ЭЗЭН” гэсэн гурван өөр нэрээр таниул гэснийг анхаар.

Эдгээр нэрс нь гэрээг сахигч Бурхантай хэрхэн холбогдож байгааг ойлгохын тулд уг гурван нэр бүгд ижил еврей אֱלֹהִים (*хаяах*) үйл үгийн хувилбарууд гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ үгийг ихэвчлэн "байх" үйл үгийн зарим хэлбэр гэж орчуулдаг. Энэхүү “БИ БОЛ БИ БАЙГАА ЮМ” гэдгийг Еврей хэлээр “Би байх Нэгэн байна” гэх ба товчхондоо “Би байдаг”, “Би байх болно” гэж ойлговол илүү хялбар. Энэ нь үйл үгийн нэгдүгээр бие дээр байдаг. Гэхдээ "Эзэн" гэж орчуулагдсан нэр нь арай илүү тайлбар шаарддаг.

"Эзэн" гэсэн нэр томъёог "ЯХВХ" гэж ихэвчлэн бичигддэг дөрвөн үсэг бүхий Бурханы Еврей нэр буюу тэнгэрлэг тетраграмматон гэдэг. Сүүлийн үеийн археологийн олдворууд энэ нэр томъёог "Яавэ" гэж дуудах ёстойг харуулдаг. Яавэг ихэвчлэн "Эзэн" гэж орчуулдаг. Гэхдээ энэ нь үнэндээ “хаяах” үйл үгийн гуравдугаар төлөөний нэрийн хэлбэр бөгөөд “Тэр байдаг” эсвэл “Тэр байх болно” гэж орчуулагдаж болдог. Үнэн хэрэгтээ, еврей хэлний зарим дүрмийн дагуу үүнийг "Тэр оршин тогтнодог" эсвэл "Тэр оршин тогтноох болно" гэсэн утгатай байж ч болох юм. Үүнтэй ижил байдлаар “БИ БОЛ БИ БАЙГАА ЮМ” гэдгийг “Би оршин

тогтнолыг оршин *тогтноодог*” гэж орчуулж болно. Мөн “БИ БАЙГАА” гэдэг нь “Би оршин *тогтноодог*” гэж орчуулж болно.

Энэхүү ойлголтыг зөв гэж үзвэл эдгээр эшлэлүүд дэх Яавэ нэр болон эдгээртэй холбоотой нэрс нь Бурхан Өөрийн гэрээний амлалтуудыг *оршин тогтноодог* гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, Тэрээр Израилын эцэг өвгөдөд өгсөн амлалтаа биелүүлснээрээ үүнийгээ гүйцэлдүүлж байна.

Бурхан гэрээний амлалтуудаа үнэнчээр биелүүлж байгааг Мосе яагаад онцлон хэлснийг ойлгоход хэцүү биш. Эхлэл 15:14-т Бурхан Израилыг харийн нутаг дахь зовлон бэрхшээлээс аврахаа амласан. Мосегийн хүлээн авагчид ч тэдний үед Бурхан энэ амлалтыг биелүүлж байсныг мэдэх хэрэгтэй байсан. Тэдний өнгөрсөн, одоо болон ирээдүйн ерөөл бүр нь тэдний тэнгэрлэг хаан нь эцэг өвгөдтэй нь байгуулсан гэрээгээ сахисны үр дүн гэдгийг тэд харах хэрэгтэй байв.

Энэ нь олон талаараа Христийн дагалдагчдын хувьд ч мөн адил байна. Бурхан Израилын эцэг өвгөдтэй байгуулсан гэрээнүүдээ *бидний* өнгөрсөн, одоо, ирээдүйд ч мөн сахидаг. Лук 1:68-73-т Абрахамтай байгуулсан Бурханы гэрээний эцсийн биелэл нь Христийн хаанчлалын эхлэлд буюу Түүний эхний ирэлтээр эхэлсэн гэдгийг бидэнд заадаг. Үүнээс гадна Галат 3:15-18-д бид Христийн хаанчлалын үргэлжлэх үед Бурханд болон Түүний Абрахамд өгсөн амлалтад нь үргэлжлүүлэн найдах ёстой тухай өгүүлдэг. Түүнчлэн Ром 4:13 дээр Христийн хаанчлал бүрэн төгс биелэх үед Христ дотор бидний хүлээн авах алдар суу бүхий мөнхийн шагнал нь Израилын эцэг өвгөдөд өгсөн Бурханы амлалтын биелэл байх болно гэж заадаг.

Бид Христ дотор байдаг. Христ бол Абрахамын гэрээний өв залгамжлагч юм. Мөн Бурхан Абрахамтай байгуулсан гэрээгээ сахиж чадалгүй бүтэлгүйтнэ гэж байхгүй. Эдгээр болон үүнтэй төстэй хэрэгжүүлэлт нь Израилын гэрээг сахигч хаан болох Бурханыг илчилсэн Гэтлэлийн багц хэсэг болгоноос урсан гарч, бидний ертөнцөд хэрэгждэг.

Израилын хөвгүүд Мосегийн эсрэг босож, урьд нь Бурханы тэдэнд хийж өгсөн зүйлсийг хүндэтгээгүй ч Тэрээр тэднийг аварна хэмээх амлалтаа биелүүлсэн. Тийм учраас Бурхан гэрээндээ үргэлж үнэнч байдаг гэдгийг Гэтлэл ном харуулдаг. Бурхан тэдний тэрслүү байдлаас болж бууж өгөхгүй байсан. Тэднийг аврахаар тавьсан зорилгодоо Тэрээр хүрэх ёстой байсан. Мөн энэ л зорилго биднийг Өөртөө улам ойртуулахын тулд бидэнд зориулан бий болгосон Бурханы зорилго мөн. Бид Бурханаас хэчнээн холдсон ч Тэрээр хичээсээр, биднийг Өөртөө улам ойртуулсаар байдаг. Бид хэчнээн холдож завхарсан ч Тэр биднийг эдгээхийн тулд бидэнд ойртон ирж, ингэснээрээ биднийг гэртээ буцаан авчирдаг. Тиймээс Гэтлэл ном бол Бурханы биднийг дуудсан амьдралын тусгал мөн. Бас Тэр чөлөөлөхийн тулд байдаг. Үнэндээ, Гэтлэл ном бол чөлөөлөлтийн ном мөн. Хүмүүс гэмд унасан, тэднийг чөлөөлөх шаардлагатай. Хүн бид өдөр бүр унадаг. Бурхан чөлөөлдөг. Тэр бол биднийг нигүүлслээс зугтах үед Өөртөө ойртуулан эргүүлэхдээ мэргэшсэн Нэгэн билээ.

- Рев. Др. Кипр К. Гучиенда

Гэтлэл 5:1–18:27-д Израилын гэрээг сахигч Бурханы талаарх гол сэдвээс гадна бид Бурханыг Израилын ялагч дайчин гэж онцолсныг анхаарах хэрэгтэй.

ЯЛАГЧ ДАЙЧИН БУРХАН (5:1–18:27)

Мосегийн үеийн томоохон эзэнт гүрэн болгоны археологийн олдворуудаас харахад тэнгэрлэг болон хүмүүн хаанчлал холбогдож байж дайнд ялалт байгуулах нь тун түгээмэл байсан байна. Тиймээс Бурханыг Израилын ялагч дайчин хэмээн дурдсан болгон Түүнийг мөн Израилын *ялагч хаан* гэдгийг илтгэж байв.

Мосег Египетэд байх үед эхлээд Бурханыг Израилын ялагч дайчин хаан гэж үзэж байсныг бид харах болно. Дараа нь Мосе болон Израилчууд Египетээс Синаи руу явах үед нь бид энэ сэдвийг судлах болно. Египет дэх Мосегийн талаарх эхлээд үзэцгээе.

Египетэд (5:1-13:16)

Энэ сэдэв нь Гэтлэл ном даяар гарах боловч бид үүнийг онцгойлон Израилын чөлөөлөлтийн үеэс харж болно. Энэ тухай 5:1–13:16 дээр гардаг. Египетийн эсрэг Бурханы гайхамшигт шүүлтүүд нь Мосегийн эрх мэдлийг зөвтгөөд зогсохгүй мөн Израилын дайчин хаан болох Бурханы ялалтыг ч мөн харуулсан.

Гэтлэл 12:12-т Бурхан Өөрийн хамгийн агуу шүүлт болох уугануудын үхэл бүхий шүүлтийн ач холбогдлыг ийнхүү дүгнэжээ:

“Би тэр шөнө Египет орон даяар явж, Египетийн нутаг дахь уугануудыг, хүн, мал гэж ялгалгүй бүгдийг цохиж, Египетийн хамаг бурхдад ял шийтгэл буулгана. Би Эзэн” гэжээ (Гэтлэл нь 12:12).

Энэ эшлэлд Бурхан “Би Эзэн” буюу “Би байдаг [Яавэ]” гэж тунхагласан болохыг анхаар. Энд дахин Бурхан гэрээгээ тогтноон биелүүлдэг Нэгэн гэдгээр таниулж байна. Израилын ялагч дайчин хаан Тэрээр "уугануудыг, хүн, мал гэж ялгалгүй бүгдийг цохиж" алах гэж байна. Өөрөөр хэлбэл, Египетчүүд өөрсдийгөө Бурханы дайсан болгосон учир Тэрээр тэднийг болон тэдний нийгмийг устгах гэж байна. Мөн хүнийг онцлохын зэрэгцээ Бурхан "Египетийн хамаг *бурхдад* ял шийтгэл буулгана". Тэрээр Египетчүүдийн шүтдэг бузар сүнснүүдийг, хуурамч бурхдыг ялах болно.

Фараон болон Египетчүүдийн эсрэг Яавэгийн гайхамшигт шүүлтүүдээс бид энэхүү хоёр давхар ялалтыг харж болно. Эдгээр шүүлтүүд бүгд биш юмаа гэхэд ихэнх нь Египетийн хэд хэдэн хуурамч бурхдын эсрэг ялалт авчирсан харагддаг. Жишээлбэл, Аароны таяг могой болж, Фараоны илбэчдийн могойг залгисан нь зөвхөн Фараоныг ялсан хэрэг биш байв. Энэ бол Фараоны титмийг чимэглэсэн наж могойгоор бэлгэдсэн тэнгэрлэг хүчийг ялсан явдал байв. Бурхан Нил мөрнийг цус болгон хувиргахдаа Тэрээр Нил мөрөнтэй холбоотой Хапи, матрын дүртэй Сепек, Хнум, загасны бэлгэдэл болсон Хатмехит зэрэг Египетийн бурхад, дагинасаас дээгүүр хүчтэйгээ харуулсан. Мэлхийн тахал нь мэлхийн толгойтой хүний дүрээр

дүрслэгдсэн Египетийн дагина Хехэтийг шийтгэх Бурханы хүчийг харуулсан. Египетийн ямар ч бурхад дэлэнчийн гамшигтай шууд холбогдох боломжгүй. Гэвч эрдэмтэд газрын бурхан Гэб байх гэх мэт хэд хэдэн санал дэвшүүлдэг. Энэ гамшиг нь мөн Египетийн тахилч нар болон илбэчдийг шившигт оруулах зорилготой байж магадгүй юм. Ялааны гамшиг нь ихэвчлэн нисдэг цох гэж дүрслэгдсэн Хепре бурханы эсрэг чиглэгдсэн байх гэж харагддаг. Малын тахал нь Апис, Бучис, Мневис, Птах, Ре зэрэг бух хэлбэрээр дүрслэгдсэн олон бурхад, түүнчлэн бурхдын хатан хаан Исис, гоо үзэсгэлэн, хайрын Хатор бурхны хүчнээс Бурхан илүү хүчтэй болохыг харуулсан байна. Эдгээр хоёр дагина нь үхрийн дүрээр дүрслэгддэг байв. Буглаат хатги тахал нь өвчин, эдгэрэлттэй холбоотой Сехмет, Имхотеп хоёрын эсрэг Бурханы хүч илүүтэйг харуулсан байж магад. Мөндрийн шүүлт нь тэнгэрийн дагина Нут болон тэнгэрийг тогтоон барьдаг гэгч Шу нарыг ялсан Бурханы хүчийг харуулсан. Царцаанууд нь хортон шавжаас хамгаалагч Сенехемийг дорд оруулсан хэрэг байв. Түнэр харанхуйн шүүлт нь нарны агуу бурхан Рэ буюу Амон-Рэгийн эсрэг үйлдсэн Яавэгийн хүчийг харуулсан. Дараа нь ууган хүүгийн үхэл буюу сүүлчийн гамшиг нь үржин олшруулдаг гэгддэг бурхад болох Мин, Исис нарыг шившиг болгосон явдал байв. Эдгээр холбоосуудыг харахад Египет дэх Бурханы гайхамшигт шүүлтүүд нь түүний бие махбодын дайснуудыг төдийгүй сүнслэг дайснууд болох Сатаны хүчийг ялсныг нь харуулсан юм.

Бид Мосег Египетэд байх үед Израилын ялагч дайчин хаан болох Бурханы тухай харлаа. Гэвч Гэтлэл 13:17–18:27-д хүмүүн болон сүнслэг дайснуудын эсрэг Бурханы ялалт нь Мосе болон Израилчууд Синаи руу явах үед мөн харагддаг.

Аяллын үед (13:17–18:27)

Мэдээжийн хэрэг Синаи Уул руу явах замд зовлон бэрхшээл дундуур Бурхан Израилын армийг удирдсан явдал нь Түүнийг Израилын дайчин хаан гэдгийг илтгэн харуулдаг. Гэхдээ энэ талыг харуулах Гэтлэлийн хамгийн сайн хэсэг бол Улаан Тэнгис дэх Мосегийн дуунаас харагдана. Гэтлэл 15:3-4 дээрх Мосегийн дууг сонсоцгооё. Энд:

“ЭЗЭН бол дайчин, Түүний нэр ЭЗЭН билээ. Фараоны зэвсэгт тэргийг цэрэгтэй нь далайд хаягч нь Тэр билээ” гэжээ (Гэтлэл нь 15:3-4).

Энд Мосе ЭЗЭНийг “дайчин” гэж шууд тодорхойлсон бөгөөд дараа нь “Түүний нэр бол [Яавэ ЭЗЭН]” хэмээн давтан хэлсэн. Дайчин Бурхан болон Бурханы нэр хоёрын хоорондох энэхүү нягт холбоо нь Хуучин Гэрээний “Түг түмдийн ЭЗЭН” эсвэл “Түмэн цэргийн Яавэ” гэсэн танил хэллэгийн үндэс суурь болсон. Түүний нэр нь илэрхийлж байгаа шиг Бурхан бол дайчин хаан, түг түмдийн цэргийг тогтноон бий болгож, дайснуудаа ялдаг Нэгэн билээ. Энэ тохиолдолд Тэрээр "Фараоны зэвсэгт тэргийг цэрэгтэй нь далайд" хаяж ялав. Дараа нь Гэтлэл 15:11 дээр Мосе мөн Бурханы ялалтын сүнслэг талыг ийнхүү тодорхойлсон. Энд:

“Аяа, ЭЗЭН, бурхдаас хэн нь Тан лугаа адил Ариун нь үлэмжийн, Алдар нь аймшигтай, Үйлс нь гайхамшигтай вэ?” гэжээ (Гэтлэл нь

15:11)

Бурханы ялалт нь Египетийн хүмүүн цэргүүдийг ялан дийлсэн төдийгүй Египетийн бүх хуурамч бурхдыг ялан дийлж хүч чадлаа харуулсан юм.

Бурхан бол ялагч дайчин юм гэдэг нь юу гэсэн үг вэ? Эртний ертөнцөд энэ нь үндсэндээ Бурхан бол бүтээлийн Эзэн, жинхэнэ Хаан гэсэн үг бөгөөд бид Гэтлэл 15-р бүлэгт яг үүнийг хардаг. 15:11 дээрх магтаалд дараах гайхалтай асуултыг асууж байна. Энд "хэн нь Тан лугаа адил вэ?" Тэгэхлээр хариулт нь хэн ч биш юм. Хэн ч байхгүй. Тодруулбал Бурхан шиг өөр ямар нэг бурхад, дагина байхгүй юм. Тэгэхээр бид Бурханыг ялагч дайчин гэж ярьж байгаа нь Бурхан гэх цолны төлөө өрсөлдөж байсан өөр олон зуун бурхдын эсрэг хүчирхэг мэдэгдэл болох нь дамжиггүй. Үндсэндээ Библийн гаргаж байгаа санаа нь ихээхэн нарийн байна. Энэ нь "хэн нь Тан лугаа адил вэ?" гэсэн асуулт тавьж байна шүү дээ. Хариулт нь хэн ч байхгүй бөгөөд гол санаа нь: Та өөр бурхад байдаг гэж бодож байж магадгүй. Гэхдээ эцсийн эцэст Бурхан гэгдэх зохистой цорын ганц оршихуй байдаг нь Эзэн мөн. Тэгээд Гэтлэл 15 нь "Эзэн үүрд мөнх хаанчилна" хэмээн төгсдөг. Ийм л дайчныг бид өөрсдийнхөө төлөө тулалдаасай хэмээн хүсэхгүй гэж үү.

- Др. Брайан Д.Рассел

Гэтлэл ном хоёр дахь үеийн хүлээн авагчдад итгэл өгөхийн тулд Фараон болон түүний хуурамч бурхдыг ЭЗЭН ялсан тухай онцолсон. Бурхан *тэдний* бие махбодын болон сүнслэг дайснуудыг нь ялж чадсан. Тэд өнгөрсөн түүхэнд Бурхан тэдний өвөг дээдсийнх нь төлөө хэрхэн тулалдаж байсныг мэдэж авсан. Ийнхүү тэд Канааныг эзлэхээр орох үед ирээдүйд нь Бурхан хэрхэн ялалт өгөхийг ч мөн мэдсэн нь лавтай.

Үүнтэй адилаар Христитгэгчид Гэтлэл номд буй Бурханы агуу ялалтын тухай мэдсэнээр Шинэ Гэрээнд Христийн ялалтын талаар заасантай хамтатган эргэцүүлэх боломжтой. Матай 12:28 ба 29, Иохан 12:31, мөн Колоссай 2:15 зэрэг хэсгүүдэд Шинэ гэрээ нь Христийг хаанчлалаа эхлүүлсэн бидний тэнгэрлэг дайчин хаан мөн хэмээн заадаг. Гэвч Есүс Сатан болон дэлхийн хуурамч бурхдыг ялах үедээ Өөрт нь бууж өгсөн бүхнийг Бурхантай эвлэрүүлж, нигүүлслээ цутгадаг билээ.

Мөн 1Коринт 15:25, Еврей 1:3, 1Петр 3:22 зэрэг хэсгүүдээс Есүс бол хаанчлалаа үргэлжлүүлсэн бидний ялагч дайчин хаан гэдгийг бид мөн олж мэднэ. Чуулганы түүхийн туршид бид дэлхий дээрх Сатан болон бусад муу сүнснүүдийг ялсан Христийн стратегийг дуурайх ёстой байв. Мөн хүмүүс Христэд итгэх итгэлээр дамжуулан Бурханаас уучлал, эвлэрлийг хүлээн авсаар байх ёстой.

Эцэст нь, 2Тесалоник 1:6 ба 7, Еврей 10:27 болон 2Петр 3:7 зэрэг багц хэсгүүдээс Христ хаанчлалаа бүрэн төгсгөх үедээ дахин тэнгэрлэг дайчин хаан болон эргэн ирэх болно гэдгийг бид олж хардаг. Харин Христ буцаж ирэхэд Түүний

нигүүлсэнгүй эвлэрлийн санал дуусгавар болно. Христ рүү ирэхээс татгалзсан хүмүүс Сатан болон түүний цэргүүдийн адил хувь заяаг буюу Бурханы мөнхийн шүүлтийг амсах болно.

Израилын гэрээг сахигч хаан, ялагч дайчин хаан болох Бурхан гэх гол сэдвүүдийг авч үзсэн тул бид одоо Гэтлэл номын гурав дахь гол сэдэв болох Израилын гэрээний хууль өгөгч Бурханы тухай Гэтлэл 19:1–24:11 дээрээс сурах болно.

ГЭРЭЭНИЙ ХУУЛЬ ӨГӨГЧ БУРХАН (19:1–24:11)

Бидний өмнө үзсэнчлэн эдгээр эшлэлүүд нь Мосегийн эрх мэдэл болон Израилын гэрээний хуульд анхаарал тавьдаг. Эртний Ойрх Дорнодод хүмүүн болон тэнгэрлэг хаадын аль аль нь өөрсдийн мэргэн ухааныг өгч буй хуулиараа харуулдаг гэж хүмүүс итгэдэг байв. Тиймээс Гэтлэлийн анхны хүлээн авагчдад Бурхан бол тэдний гэрээний хуулийг өгөгч хаан гэж хэлэх нь тэднийг гайхшируулахгүй байх байсан. Гэхдээ Мосе энэ сэдвийг хэрхэн онцолсныг ойлгохын тулд Бурхан *яагаад* Гэтлэл номд хуулиа өгснийг олж мэдэх нь их тус болно.

Протестантын гол уламжлал бүр нь хуулийн үндсэн гурван хэрэглээний талаар ярьдаг. Эхнийх нь "*усус педагогикус*" гэж дуудагддаг хуулийн сурган хүмүүжүүлэх хэрэглээ юм. Галат 3:23-26, Ром 3:20, Ром 5:20 ба 21 зэрэг Шинэ Гэрээний хэсгүүдэд Бурхан нүглийг мэдүүлж, илчлэхийн тулд хуулийг ашигладаг гэж заадаг. Ийнхүү хууль нь хүн төрөлхтнийг Христ рүү авралд хөтөлдөг. Хоёрдугаарт, протестантууд хуульд "*усус сивилус*" буюу хуулийн иргэний буюу улс төрийн хэрэглээ бий гэж үздэг. Энэхүү хэрэглээнд хууль нь Бурханы шийтгэлээр дамжуулан нийгэм дэх нүглийг хязгаарлаж байдаг аж. Хэдийгээр эдгээр үзэл баримтлал нь ерөнхийдөө Бичвэрийн сургаалын дагуу үнэн боловч Гэтлэл номд "хуулийн гурав дахь хэрэглээ" гэдгийг онцолсон байдаг. Үүнийг заримдаа "*усус нормативус*" буюу норматив хэрэглээ юм уу "*усус дидактикус*" буюу зааварлах хэрэглээ гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд Бурханы хууль бол аль хэдийн Түүний нигүүлсэл дор байгаа хүмүүсийн хувьд хэм хэмжээ (норм) буюу заавар юм. Тиймээс, Гэтлэл номд Бурхан үндсэндээ Өөрийн ард түмэн болох Израилыг Өөрийн ерөөл рүү дагуулахын тулд хуулийг өгсөн.

Энэ сэдэв нь Гэтлэлийн олон газарт бий. Гэхдээ энэ нь ялангуяа 19:1–24:11 дээр Бурханы Израилтай байгуулсан гэрээг эхлүүлэх үед, мөн гэрээг баталгаажуулах үед ч үргэлжлэн гарч ирдэг. Гэтлэл 19:4-т Бурхан Израилчуудад юу гэж хэлснийг сонсоцгооё. Энд:

“Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн Өөртөө яаж авчирсныг та нар өөрсдөө харсан” гэжээ (Гэтлэл 19:4).

Израилчууд хуулийг хүлээн авахаас өмнө Бурханы нигүүлслийг аль хэдийн мэдэрсэн байсныг бид эндээс харж байна. Тэгээд 5 ба 6-р эшлэлүүдэд Бурхан Израилын хуулийг дуулгавартай дагах шаардлага болон үнэнч байхын ашиг тусын талаар өгүүлсэн. Тэрээр хэлэхдээ:

“Хэрэв та нар одоо Миний үг дууг дуулгавартай дагаж, Миний гэрээг сахих аваас та нар бүх ард түмний дундах Миний үнэт өмч байх болно. Учир нь бүх дэлхий Минийх. Та нар Надад тахилчдын хаант улс, ариун үндэстэн болох болно.” Энэ үгсийг чи Израилын хөвгүүдэд хэл гэв” гэжээ (Гэтлэл 19:5-6).

Бурханы нигүүлслийг аль хэдийн хүлээн авсан Израил нь хуулийг дагаж мөрдвөөс Түүний "үнэт өмч", "тахилчдын хаант улс, ариун үндэстэн" байх болно. Израилчууд авралыг *олж авахын* тулд Бурханы хууль өгөгдөөгүй нь тодорхой харагдаж байна. Энэ хууль бол ард түмэндээ өршөөл энэрлээ үзүүлснийхээ дараа тэдэнд өгсөн Бурханы бэлэг байв.

Үүнтэй төстэй хэв загвар Гэтлэл 20:1-17-д гардаг. 20:2-т Бурхан Арван Хуулийг эхлүүлж, Израилд хандсан Өөрийн энэрлээ тунхагласан байдаг. Энд:

“—Чамайг Египетийн газраас, боолчлолын гэрээс гаргасан Би ЭЗЭН, чиний Бурхан” гэжээ (Гэтлэл 20:2).

Бурханы нигүүлсэл нь Израилд өгсөн Түүний хуулиас өмнө байсныг бид дахин нэг удаа харлаа. Энэ тунхаглалын дараа л Бурхан Израилд Арван Хууль өгсөн байна. Арван Хуулийн олонход нь тодорхой дурдсанчлан Израил хуульд дуулгавартай байснаараа ерөөл хүртэх аж.

Магадгүй зарим хүмүүс Бурханы хуулийг хязгаарлагдмал бөгөөд нигүүлсэлтэй зөрчилддөг гэж бодож байж болох юм. Гэвч Бурхан Хуучин Гэрээнд хуулийг өгсөн арга замыг харвал хуулийг өгсөн нь Түүний хувьд нигүүлсэнгүй зам байсныг харж болно. Бидний харж байгаачлан Бурхан ард түмнээ Египетийн боолчлолоос гэтэлгэн чөлөөлсний дараа тэдэнд хуулийг өгсөн байна. Тэр тэднийг дагуулан гарч, хүчирхэг үйлсээ үйлдэн, дараа нь тэднийг цөлд аваачин, өршөөлөө үзүүлэн, тэдний агуу Хаан болох Бурханы эзэмшил ба хаанчлалын дор хэрхэн амьдрах тухай Өөрийн төлөвлөгөөгөө илчилсэн. Тиймээс хууль бол Бурхан ард түмнээ сахиж мөрдсөнийх нь *дараа* тэднийг золин аврахын тулд өгсөн зүйл биш юм. Үүний оронд хууль нь Бурхан тэднийг Египетээс гэтэлгэж, ард түмэндээ агуу Хаан болох Бурханы эзэмшил дор хэрхэн амьдрах ёстойг, мөн тэд аврагдсан ард түмний ёсоор хэрхэн амьдрах ёстойг харуулсны *дараа* өгөгдсөн. Тиймээс та Хуучин Гэрээнд байгаа хуулийн талаар унших бүрдээ энэ нь Бурхан ард түмэндээ нигүүлсэнгүй өгөөмөр хандсан учраас өгөгдсөн гэдгийг мэдэж болно.

- Др. Брендон Д. Кроу

Гэрээг баталгаажуулах үеэр Бурхан мөн энэ хэв маягийг бас харуулсан. Гэтлэл 24:1 ба 2-р Тэрээр Израилын удирдагчдыг Синаи Уулан дээр Өөр рүү нь ирэхийг эелдгээр урьсан. 3-8-р эшлэлд хүмүүс хуулийг дагаж мөрдөхөө тангараглав. Мөн 9-11-р эшлэлд Израилын удирдагчид Бурхантай энх тайвны ерөөлийг тэмдэглэж, Бурханыг бас бодитоор харсан.

Анхны хүлээн авагчдын хувьд өнгөрсөн дэх Бурханы хуулийн нигүүлсэнгүй, ашиг тустай шинж чанарыг онцлон тэмдэглэсэн нь тэднийг өөрсдийн цаг үед үүнийг дагах хэрэгтэйг сануулж байна. Хууль бол тэдний одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн нөхцөлд нь ч өгсөн Бурханы бэлэг байсан.

Христийн дагалдагчдын хувьд бид Гэтлэл номоос Израилд өгсөн Бурханы тушаалуудыг харах бүрдээ тэдгээрийг Христ дотор бидэнд өгсөн Бурханы нигүүлсэл, ач тустай бэлэг гэж үзэх ёстой.

Харин хаанчлалаа эхлүүлэх үедээ Есүс, Түүний элч нар болон эш үзүүлэгчид Мосегийн хуулийг бидний үед хэрэгжүүлэхэд туслах шинэ илчлэлүүдийг чуулганд өгсөн гэдгийг бид мэднэ. Гэвч Матай 5:17, Ром 8:4, Еврей 8:10 зэрэг эшлэлүүд нь Есүс болон Түүний дагалдагчид Мосегийн хуулийн эрх мэдлийг үл тоомсорлодоггүй гэдгийг тодорхой харуулж байна. Хаанчлалын үргэлжлэх үед ч мөн дээрхтэй адил байна. Өнөөдөр бид Христ ирээгүй мэт Бурханы хуулийг сахих гэж оролдох ёсгүй. Гэхдээ бид үүнийг өнөөдөр Христ дэх Бурханы цаашдын илчлэлийн хүрээнд хэрэгжүүлэх ёстой. Бидний мэдэж байгаагаар, Христ хаанчлалаа бүрэн төгс болгохоор буцаж ирэхэд Түүний ард түмэн бүрэн ариусгагдах болно. Дараа нь бид шинэ бүтээлд бидний зүрх сэтгэлд бичигдсэн Бурханы төгс хуулийг дагах болно.

Бид Бурханыг Израилын гэрээг сахигч хаан, ялагч дайчин хаан, гэрээний хууль өгөгч хааны хувьд судалснаар Гэтлэл номын гол сэдвүүдийг авч үзлээ. Эцэст нь Гэтлэл 24:12–40:38-д буй Израилтай хамт буй дайчин болох Бурханы тухай сэдвийг харцгаая.

ХАМТ БУЙ ДАЙЧИН БУРХАН (24:12–40:38)

Гэтлэл ном нь Израилыг захирах Эзэний хаанчлалын талаар маш сонирхолтой ойлголтыг харуулдаг. Хүмүүс Хуучин Гэрээг судлахдаа Израилын анхны хааныг Саул гэж боддог. Тэр бол анхны хүмүүн хаан мөн. Харин Гэтлэл 19:5-6-р эшлэлүүдийг уншихад Израилыг “тахилчдын хаант улс” гэж өгүүлдэг. За тэгэхлээр, та хаангүйгээр хаанчлалтай байж чадахгүй шүү дээ. Тиймээс Гэтлэл 19:5-6-д дурдсанаар бол Израилын анхны хаан нь үнэндээ Бурхан Өөрөө юм. Хэдийгээр Бурхан Хуучин Гэрээнд Христ дотор бие махбодтой болоогүй байсан ч өдөр нь үүл, шөнө нь галан баганаар Өөрийгөө хаан гэдгийг, мөн Христ доторх хаанчлалаа харуулсан. Асар нь Иммануел буюу "Бурхан бидэнтэй хамт" гэсний бэлгэдэл болдог. Тиймээс Бурханы хаанчлал нь Израилд өгсөн эдгээр дүрслэл, бэлгэдлүүдээс харагддаг бөгөөд Тэрээр Израилд Христээр дамжуулан Өөрийн засаглал, хаанчлалаа харуулдаг.

- Др Дон Коллетт

Бид Гэтлэл 24:12–40:38 дээрээс Бурханы хааны оршихуйн талаар илүү тод хардаг. Энэхүү Гэтлэлийн дөрөв дэх гол хэсэг нь Мосегийн эрх мэдэл болон Израилын асарт голлон анхаардаг. Эдгээр бүлгүүдэд Бурхан Мосед асрын талаар зааварчилгааг хэрхэн өгсөн, Израил Синаи Уулын бэлд хэрхэн бүтэлгүйтсэн, Мосе асрын барилгын ажилд Израилыг хэрхэн удирдаж байсныг хүүрнэдэг. Эдгээр үйл явдал бүр нь Бурханы оршихуй нь ард түмэнтэйгээ хамт байдгийг онцолсон. Гэтлэл 33:14-т Бурхан Мосед энэ талаар батлан өгүүлдэг. Энд:

“Миний оршихуй хамт явж, Би чамд амралтыг өгнө гэв” гэжээ (Гэтлэл 33:14).

Энэ эшлэлд буй "Миний оршихуй" гэсэн хэллэг нь ихэвчлэн "царай" гэж орчуулагддаг *אָנִי* (*паним*) гэх еврей нэр үг байдаг. Гэтлэл номын олон хэсэгт Бурханы “царай” гэдэг нь Түүний онцгой, идэвхтэй, анхаарал халамжтай, ихэвчлэн харагдахуйц оршихуйг нь илэрхийлдэг.

Хэдийгээр Бурхан хаа сайгүй оршдог авч Библийн туршид онцгой арга замаар ард түмэндээ Өөрийгөө зориулсан байдаг. Гэтлэлийн энэ хэсэгт Бурханы оршихуй асарт болон үүний ойролцоо оршдог байв. Бид энэ хичээлийн эхэнд дурдсанчлан, асар нь мөргөлийн танхим юмуу эсвэл Израил мөргөл үйлддэг газраас хамаагүй илүү утгатай байв. Израилчууд асарт Бурханд мөргөдөг байсан. Учир нь энэ нь Бурханы хаанчлалын дайны майхан байсан юм. Эртний хүмүүн хаад цэргээ удирдан тулаанд орох үедээ дайны майхандаа байдаг байсантай адил Бурхан Израилын цэргийг удирдан Канааныг байлдан дагуулах үедээ Өөрийн асартаа амьдарч байжээ.

Харин одоо Гэтлэл 32:1–34:35-г харвал Бурханы оршихуй ард түмэнтэйгээ хамт байх нь аюул занал болж хувирав. Энэ хэсэгт бид Синаи Уулан дахь Израилын уналт болон сэргэлтийн талаар олж мэднэ. Израилчууд Синаи Ууланд алтан тугалд мөргөж байгааг Бурхан анх хараад Мосегоос бусад бүх үндэстнийг устгана хэмээн сүрдүүлсэн. Гэвч Мосегийн зуучлан гуйлтын тусламжтайгаар Бурхан тэднийг устгахаас татгалзаж, зөвхөн нүгэл үйлдсэн хүмүүсийг шийтгэсэн. Гэсэн хэдий ч Бурхан ард түмнээ урагшлах үед, тэднээс Өөрийн оршихуйг зайлуулна гэж сүрдүүлдэг. Гэсэн ч тэнгэрлэг хааны оршихуй байхгүйгээр урагш алхана гэдэг нь тэдний санаанд багтамгүй үйл явдал байлаа. Гэтлэл 33:15-16 дээрээс Мосегийн Бурханд хэлсэн үгийг сонсоцгооё. Тэрээр энд:

“Хэрэв Таны оршихуй хамт явахгүй бол биднийг эндээс бүү явуулаач. Эс тэгвэл би болон Таны ард түмэн мэлмийд тань тааллыг олсон нь юугаар мэдэгдэх вэ? Та бидэнтэй хамт явж байгаагаар бус уу? Тэгвэл би болон Таны ард түмэн бид газрын хөрсөн дээр буй бүх ард түмнээс ялгагдах юм гэв” гэсэн байна (Гэтлэл 33:15-16).

“Хэрэв Таны оршихуй [тэдэнтэй] хамт явахгүй бол” Израилыг түрүүлж битгий явуулаач гэж Мосе Бурханаас гуйсныг эндээс анзаараарай. Тэдний хооронд

бүх зүйл асуудалгүй зөв байгаа гэдэгт Мосе итгэлтэй байхыг хүсжээ. Тэднийг “газар дээрх бүх ард түмнээс ялгагдах” зүйл нь болсон Бурханы оршихуйг тэдэнтэй хамт байлгахын тулд үүнийгээ тэднээс бүү аваач хэмээн Мосе гуйжээ. Гэтлэл 33:17-р эшлэлд Бурхан ийнхүү хариулсан байдаг. Энд:

“Чиний хэлсэн энэ зүйлийг Би бас хийнэ. Учир нь чи Миний мэлмийд тааллыг олсон. Би чамайг нэрээр чинь мэддэг гэж айлдав” гэжээ (Гэтлэл 33:17).

Номын сүүлчийн эшлэл болох Гэтлэл 40:38-д асарт Бурханы оршихуй Израилтай хамт байгааг онцолсонд гайхах хэрэг алга. Энд:

“Учир нь бүх аян замынх нь туршид Израилын бүх гэрийн нүдэн дээр ЭЗЭНий үүл өдөр нь асрын дээр байж, шөнө нь түүн дээр гал үзэгддэг байв” гэжээ (Гэтлэл 40:38).

Бурхан ард түмэнтэйгээ хамт байдаг. Тэрээр бутан дунд үзэгдэн, Мосетой хамт байв. Тэр ард түмэнтэйгээ галан ба үүлэн баганаар хамт байж, шөнө нь гал, өдөр нь үүлээр удирдсан. Тэгээд бид номын сүүлийн бүлгүүд рүү шилжих үед, номын ихэнх хүмүүсийн үл тоомсорлодог хэсгүүд дээр Бурхан тэдэнд майхныг, асрыг өгсөн байдаг. Мөн энэ асар дотор Тэрээр тэдэнд оршихуйг нь бэлгэддэг Гэрээний авдрыг өгдөг. Энэ талаарх миний хамгийн дуртай зүйл бол Бурхан нь ард түмэнтэйгээ хамт байхыг хүсдэг Бурхан гэдгийг олж харах явдал байдаг. Энэ нь миний хувьд Иохан 1-р бүлэгт өгүүлдэг зүйлийн зөгнөл гэж боддог. Энд хэлэхдээ:

Үг нь махбод болж, бидний дунд оршин буюу Иохан 1:14 нь шууд утгаараа мах бод болж гэдгийг асар болж гэж хэлдэг.

Хуучин Гэрээн дэх Бурхан ард түмэнтэйгээ хамт байхыг хүсдэг бөгөөд эцэст нь Бурхан Өөрийн Хүү Есүсийг Шинэ Гэрээнд хүмүүстэйгээ хамт байлгахаар илгээсэн.

- Др. Давид Т. Ламб

Шинэ Гэрээ нь Христийн хаанчлалын гурван үе шат бүрд Христийн дагалдагчдад Бурханы онцгой хааны оршихуйн энэхүү гол сэдвийг хэрэгжүүлж байдаг. Матай 18:20, Иохан 2:19-21 зэрэг нь Хаанчлалынхаа эхлэл үеэр Христ Өөрөө ард түмэнтэйгээ хамт буй Бурхан хааны ер бусын оршихуй болж байсан гэдгийг тайлбарладаг. Үнэн хэрэгтээ, Иохан 1:14 нь Израилын асар болон Есүсийн анхны ирэлтийн хооронд тодорхой холбоосыг бий болгодог. Энэ тухай хэлэхдээ:

“Үг нь махбод болж, бидний дунд оршин, Бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба

үнэнээр дүүрэн юм” гэдэг (Иохан 1:14).

"Бидний дунд оршин" гэсэн хэллэг нь Грекийн σκηνώω (*скеноо*) гэсэн үгнээс гаралтай. Грек хэл дээрх Хуучин Гэрээ болох Септуагинтад *σκηνή* (*шакан*) гэсэн еврей үйл үг бүхий ижил нэр томъёог ашигласан бөгөөд Гэтлэл номд асартаа буй Бурханы оршихуйг хэлдэг. Тиймээс энэ эшлэл нь Христийн биежилт нь Өөрийн ард түмнийг ялалт руу хөтөлж байсан Бурхан байсныг заадаг.

Нэмж дурдахад, Үйлс 2:17, Ром 5:5 зэрэгт Есүс тэнгэрт одохдоо Өөрийн дагалдагчдадаа Сүнсээ асгаана хэмээсэн байдаг. Тиймээс Христийн хаанчлалын үргэлжлэх үед Ариун Сүнс нь Түүний чуулганд оршоор ирсэн. Бурхан майхныг Өөрийн оршихуйгаар дүүргэдэг байсан шиг Сүнс Өөрийн хүмүүсийг өдөр бүр Бурханы удирдамж, ялалт буйг батлан онцгой, хүчит оршихуйгаар дүүргэдэг.

Мэдээжийн хэрэг Илчлэл 21:3 гэх мэт Шинэ Гэрээний хэсгүүд нь Христийн биежилт болон Сүнсний оршихуй нь шинэ бүтээл дэх Бурханы гайхамшигт оршихуйн урьдчилгаа гэдгийг заадаг. Христ хаанчлалаа бүрэн төгс болгохоор ирэхдээ бүх зүйлийг шинэ болгоно. Мөн бүх бүтээл бидэнтэй хамт буй дайчин хааны тодорхой үзэгдэх сүр жавхлангаар дүүрэх болно.

ДҮГНЭЛТ

“Гэтлэл номын тойм” нэртэй энэ хичээлээрээ бид уг номыг судлахдаа анхаарах шаардлагатай зүйлс, номын бичээч, нөхцөл байдал, анхны утга ба орчин үеийн хэрэгжүүлэлт зэрэгтэй танилцлаа. Мөн бид уг номын бүтэц болоод агуулгыг үндсэн хоёр хэсэгт хувааж судалсан. Түүнчлэн бид номын туршид хаан болох Бурханы тухай хэд хэдэн талыг хамарсан сэдвүүдээс үзсэн бөгөөд хэрхэн онцолж байгааг нь харсан.

Амлагдсан Газрын хил дээр Мосетэй хамт буудалласан анхны Израил хүлээн авагчдад Гэтлэл ном асар их ач холбогдолтой байсан. Израилчууд өөрсдийн цаг үедээ Бурханы төлөө амьдрах сорилтуудын талаар эргэцүүлэн бодож байх үед тэднийг үндэстнийхээ Бурханаас томилогдсон удирдагчийнх нь хувьд Мосед үнэнч байхаа дахин батлахыг Гэтлэл ном уриалав. Энэ ном тэднийг Египетээс Синаи Ууланд хүргэн, чөлөөлөхөд оролцсон Мосегийн гүйцэтгэсэн үүргийг тэдэнд сануулжээ. Мөн энэ нь Бурхан тэднийг Амлагдсан Газарт хэрхэн бэлтгэснийг тэдэнд сануулсан юм.

Яг үүнтэй адилаар өнөөдөр Христийн дагалдагчдын хувьд Гэтлэл ном нь биднийг Мосегийн эрх мэдэлд үнэнч гэдгээ батлахыг уриалж байна. Гэвч энэ нь Бурханы Христ дотор хийсэн зүйлийн хүрээнд байх ёстой аж. Израилын удирдагчийн хувьд Бурхан Мосегоор дамжуулан хэчнээн их зүйлийг хийсэн шиг, Гэтлэл ном нь Бурхан Христээр дамжуулан хэчнээн агуу үйлсийг гүйцэлдүүлснийг бидэнд харуулдаг. Христ дотор Бурхан биднийг нүглийн боолчлолоос болон Сатаны ноёрхлоос үүрд чөлөөлсөн. Мөн Христ дотор Бурхан бидэнд Христийн Сүнсний оршихуй болон биднийг удирдан чиглүүлэх зааварчилгааг ч өгсөн. Энэ үүднээс Гэтлэл ном бидэнд шинэ тэнгэр, шинэ газарт амласан бидний мөнхийн өв рүү Христ

биднийг хөтлөх үед Түүнийг хэрхэн дагах талаар илүү ихийг мэдэх тоо томшгүй олон боломжийг олгодог.

ХУВЬ НЭМЭР ОРУУЛАГЧИД

Др. Скот Рэд (Хөтлөгч) бол Вашингтон Д.С дэх Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Ерөнхийлөгч, Хуучин Гэрээний Дэд Профессор. Др. Рэд нь M.Div. зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуулиас авсан. М.А болон Ph.D зэргээ АНУ-ын Католик Их Сургуулиас авсан. Тэрээр мөн Малта дахь АНУ Католик Их Сургууль, Августин Теологийн Институти болон Газар дундын тэнгисийн Олон Улсын Сургалтын Хүрээлэнд багшилж байсан. Др. Рэд нь олон төрлийн ном зохиолыг хамтран бичсэн. Үүнд: *Tabletalk* (Ligonier Ministries), *The Washington Post* болон *First Things*. Түүнчлэн тэрээр *Constituent Postponement in Biblical Hebrew Verse* (Society of Biblical Literature, 2014) болон *Wholehearted: A Biblical Look at the Greatest Commandment and Personal Wealth* (Institute for Faith, Work & Economics, 2016) зэрэг номуудыг бичсэн.

Др. Роберт Б. Чишолм, Жр. бол Далласын Теологийн Сургуулийн тэнхимийн захирал, Хуучин Гэрээний профессор

Др. Дон Коллетт нь Үйлчлэлийн Тринити Сургуулийн Хуучин Гэрээний туслах профессор

Др. Брендон Д. Кроу нь Вестминстерийн Теологийн их сургууль Шинэ Гэрээний туслах профессор

Проф. Томас Эггер нь Конкордиа Библийн их Сургууль Тайлал Теологийн туслах профессор

Др. Дуглас Гропп нь Редиймер Библийн их Сургууль Хуучин Гэрээний профессор асан, Хичээлийн дэд эрхлэгч.

Рев. Др. Сиприан К. Гучиенда бол Техас мужийн Даллас дахь Хайя Ланд Парк Бүх Үндэстний просбитериан чуулганы пастор

Др. Гордон Х. Жонстон бол Даллас Теологийн Сургуулийн Хуучин Гэрээний профессор

Др. Давид Т. Лэмб бол Библийн Теологийн Семинарын Хуучин гэрээний дэд профессор

Др. Ричард Л. Прагт. Жр бол Гурав дахь мянган үйлчлэлийн хамтран үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч, Шинэчлэлийн Теологийн Сургуульд Хуучин Гэрээний профессор

Др. Брайн Д. Рассел бол Флоридагийн Орlando дахь Асбури Теологийн

Сургуулийн Библи Судлалын Профессор, Урбан Үйлчлэлийн Сургуулийн Эрхлэгч

ҮГСИЙН ТАЙЛБАР

далд зөгнөл – өмнө нь байсан хүмүүс, юмс, үйл явдлууд нь хожмын хүн, юмс, үйл явдлыг хэрхэн урьдчилан зөгнөж буйг тодорхойлоход хэрэглэгддэг "урьдач зөн" эсвэл "урьдач дүрслэл" гэдгийн өөр нэг үг

Гэрээний Ном – Гэтлэл 20:18–23:33 дээр Синаи Ууланд Бурханы Мосед өгсөн хуулиудын эмхэтгэл

хиасм/хиастик – үндсэн хэсгийн өмнө болон хойно байрлах хэсгүүд нь хоорондоо зэрэгцсэн эсвэл харилцан тэнцвэртэй байдаг уран зохиолын бүтэц

Хаммурабигийн Код - МЭӨ 1754 оны орчимд байсан, эртний Вавилоны хууль тогтоомжийн эмхэтгэл

Эскатологи - Эцсийн өдрүүдийн онол сургаал буюу судлал

гэр шам – "тэнд цагаач болсон" гэсэн утгатай Еврей нэр томьёо (галиг)

хаммишпатим- Хууль ёсны шүүх буюу жишиг хуулиуд гэсэн утгатай Еврей нэр томьёо (галиг)

хаяах – "байх" эсвэл "оршин тогтноох" гэсэн утгатай Еврей үг (галиг) ба "Би бол Би байдаг", "Би Байгаа", "Эзэн" гэсэн нэр томьёоны үндэс

Машах – Мосе гэдэг нэртэй ижил сонсогддог гаргаж авах гэсэн утгатай Еврей нэр томьёо (галиг)

Мосе– Израильчуудыг Египетээс удирдан гаргасан Хуучин Гэрээний эш үзүүлэгч ба чөлөөлөгч. Бурхан түүнтэй “хуулийн гэрээг” байгуулж, арван тушаал болон Гэрээний номыг Израильчуудад өгсөн. Тэрээр Есүсийн дүр хувирах үед эш үзүүлэгч Элиатай хамт үзэгдсэн нэгэн юм

Синаи - Мосегийн үед Бурхан Израилтай гэрээ байгуулж, тэдэнд Арван Хуулиа өгсөн уул

эзэн хаан ба харьяат хааны хэлэлцээр – байлдан дагуулагч эзэн хаан ба харьяанд нь буй захирагч эсвэл хааны хооронд байгуулсан гэрээ

тетраграмматон - "ЭЗЭН/ЯХВХ" буюу Бурханы дөрвөн үсэг бүхий Еврей нэр

Өмнөх ертөнц – Библийг бичээчдийн түүхийг нь бичиж буй дэлхий ертөнц

Тэдний ертөнц – Бичвэрийн уншигчдын амьдарч байгаа цаг хугацаа, дэлхий ертөнц

усус сивилус – Бурханы шийтгэлийн сүрдүүлэг дор нийгэм дэх гэм нүглийг хязгаарлахын тулд хуулийг иргэний эсвэл улс төрийн зорилгоор ашиглах явдал

усус дидактикус – Бурханы нигүүлсэл дор аль хэдийнээ байгаа хүмүүст хэрхэн илүү ёс зүйтэй амьдрахыг зааварлахын тулд хуулийг хэм хэмжээ буюу жишиг болгон ашиглах явдал. Энэ нь "хуулийн гуравдахь хэрэглээ" (мөн *усус нормативус* буюу "хэм хэмжээт хэрэглээ")

усус нормативус – Бурханы нигүүлслийн дор аль хэдийнээ байгаа хүмүүст хэрхэн илүү ёс зүйтэй амьдрахыг зааварлахын тулд хуулийг хэм хэмжээ буюу жишиг болгон ашиглах явдал. Энэ нь "хуулийн гурав дахь хэрэглээ" (мөн *усус дидактикус* буюу "зааварчлах хэрэглээ" гэдэг)

усус педагогикус – Нүглийг илчлэх, хүмүүсийг Христ рүү авралд хүргэхийн тулд хуулийг сурган хүмүүжүүлэх (сургамжтай) байдлаар ашиглах явдал

Яавэ – Ихэвчлэн “ЭЗЭН” гэж орчуулагддаг, “Би бол Би байгаа” гэдэг хэлцээс гаралтай Бурханы Еврей нэр